

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, Мягмар гараг

	Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
	Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 18
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	19 - 79
1.	<i>Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төсөл /Санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/</i>	21 - 31
2.	<i>Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/</i>	31 - 36
3.	<i>Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	36 - 67
4.	<i>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	67 - 71
5.	<i>“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	71
6.	<i>Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/</i>	71 - 73
7.	<i>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын гишүүд 2024.04.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	73 - 79

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 05 дугаар сарын 14-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 37 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Б.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд;

Тасалсан: Ш.Адъяаа, Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Л.Мөнхбаатар.

Нэг.Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төсөл /Санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Ж.Соёлмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төслийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх

асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төслийг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Шүүхийн сахилгын хорооны гишүүн С.Энхтөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль тогтоомжийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Б.Болд, Нээлттэй нийгэм форумын менежер П.Бадамрагчаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Шүүх байгуулах тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

**Нэг.ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН
ТОМЬЁОЛОЛ**

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 7, 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7, 8, 13, 14 дэх заалт болгох:

7	Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
---	---	------------------	--

8	Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
14	Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 22, 23 дахь заалтын “тойргийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн Нэг, Хоёр дахь хэсгийн 3 дахь заалтын “Улаанбаатар хот” гэснийг “Улаанбаатар хотын Налайх дүүрэг” гэж, Нэг, Хоёр дахь хэсгийн 4 дэх заалтын “Улаанбаатар хот” гэснийг “Улаанбаатар хотын Багануур дүүрэг” гэж, мөн зүйлийн Гурав, Дөрөв дэх хэсгийн “Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэснийг “Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3

Бүгд: 11
72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

**Хоёр.ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН
ТОМЬЁОЛОЛ**

**1.ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ**

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**2.ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙГ ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хэрэг, маргааныг” гэснийг “эрүү, иргэний хэрэг, маргаан, эрүүгийн хэргийн шүүх харьяаллын шийдвэрлэх зөрчлийн хэрэг маргааныг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “20... оны дүгээр/дугаар сарын ... -ны өдрийн дотор” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга”-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсэгт заасан анхан болон давж заалдах шатны шүүхэд шүүгчийг томилуулах тухай саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт, Хоёр дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалт, мөн зүйлийн Гурав, Зургаа дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

4.МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ц.Сэргэлэн нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр нар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 6
Бүгд: 10

40.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ш.Адъяаа, Д.Ганбат нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “тухайн шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан бол” гэснийг “тухайн шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан шүүгчийг албан ажлын зайлшгүй шаардлагаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Б.Пүрэвдорж нар санал хэлэв.

Д.Цогтбаатар: 3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “Улсын дээд шүүхтэй зөвшилцөж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав нар тайлбар хийв.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “89 дүгээр зүйлийн” гэсний дараа “89.1 дэх хэсгийн “, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан” гэснийг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 6

Бүгд: 12

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

5.ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13 дахь хэсэг нэмсүгэй:

“13.Энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ, энэ хуулийн 31.4, 31.5 дугаар зүйлд заасан баривчлах ажиллагаа, Арван долдугаар бүлэгт заасан хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийг нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх хянан шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн ““АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ” гэсний дараа “НЭГДҮГЭЭР ДЭД БҮТЭГ” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “шүүхийн” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж, “шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж,” “31.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж, 31.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

Д.Цогтбаатар: 5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Шүүх шүүх байгуулах тухай хууль /Шинэчлэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

7.ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

8.ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

9.“ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр горимын санал хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын “нэмэлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Г.Амартүвшин нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх:

“3/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцсэн зориулалтын шаардлага хангасан шүүхийн байраар хангах хүртэлх хугацаанд нийслэл дэх зарим шүүхийг байраар хангаж, шүүн таслах ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

“4/Нийслэлд гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны тойргийн шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

“5/Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн давж заалдах шатны шүүхийг тойргоор байгуулах асуудлыг судалж, холбогдох хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх:

“6/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг эрэн сурвалжлах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэгжийн орон тоо, төсвийг нэмэгдүүлэх, холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтын 2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Шүүх байгуулах тухай /Шинэчилсэн найруулга/ баталсантай холбогдуулан прокурорын байгууллагын орон тоо, төсөвт өөрчлөлт орох эсэхийг судлан үзэж, шаардлагатай бол саналаа боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэхийг Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайханд.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Н.Даваадогтох, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн

албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн М.Ганбагана нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн тавьсан асуултад Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Н.Даваадогтох нар хариулж, тайлбар хийв.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Н.Даваатогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, Санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Б.Төрбат, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд, Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах хорооны Ажлын албаны төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч Ц.Батгэрэл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Д.Батцэнгэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн С.Энхжаргал, Нийслэлийн Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн М.Уранбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Байнгын хорооны

асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Д.Цогтбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “тухайн хотод” гэснийг “тухайн шүүхэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танлцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын гишүүд 2024.04.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Г.Нарантуяа, Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс, Улсын Ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Т.Амарзаяа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа Б.Нямгомбо, Хуульч, өмгөөлөгч Ч.Өнөржаргал, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн зөвлөх П.Цэцэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 9
Бүгд: 11
18.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 35 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 16 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
11 цаг 37 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг эрье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Ирц 68 хувьтай байна.

Хуралдааны ирцийг сая танилцуулсан.

Байнгын хорооны хуралдааны ирцийг гишүүн тус бүрээр танилцуулъя. Дамдины Цогтбаатар гишүүн, Ширнэнбандийн Адьшаа гишүүн, Ганибалын Амартүвшин гишүүн, Норовын Алтанхуяг гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн, Ням-Осорын Учрал гишүүн, Батгөмөрийн Энхбаяр гишүүн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн гэсэн гишүүд ирцэд ирсэн байна.

Ирц 68 хувь гэж түрүүн хэлсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээр асуудал, Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төсөл.

Засгийн газар 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зөвшилцөхөөр ирүүлсэн. Санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

Хоёрдугаар асуудал, Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зөвшилцөхөөр ирүүлсэн. Санал дүгнэлтээ Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

Гурав. Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газар 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.

Дөрөв. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Тав. “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн олгох

тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Зургаа. Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

Долоо. Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2025 оны төсвийн төслийг хэлэлцэх.

Найм. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

С.Одонтуяа нарын гишүүд 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Ийм 8 асуудал өнөөдөр хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон байгаа.

Гишүүд ээ, энэ дээр нэг ийм асуудал байна.

Ер нь зүгээр ажлын эрх ашгаа бодоод энэ дээр би аль болох орж ирж байгаа асуудлуудыг дэмжиж оруулах тал дээрээ ажиллаж байгаа.

Гэхдээ энэ дээр 4 байгууллагын төсвийн асуудал байна шүү дээ. 7 дугаар асуудал.

Энэ дээр Засгийн газраас төсвийн хүрээний мэдэгдэл өөрөө эцэслэн боловсрогдож орж ирээгүй байгаа юм. Тийм. Батлагдаж өөрөө дуусаагүй байгаа.

Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэл өөрөө батлагдаж дуусаагүй байхад бид энэ төсвийг Байнгын хороогоороо хэлэлцэж болохгүй байгаад байна.

Тэгэхээр би ямар зарчмын санал гаргамаар байна гэхээр. Би сая уншиж танилцуулсан 8 асуудал байгаа.

Тэгэхээр эндээс 7 дугаар асуудлыг хасаад, тэгээд өөрөөр хэлбэл 8-аас 7 асуудал үлдэж байна шүү дээ. 7 дугаар асуудал хасагдаад.

Тэгээд энэ төсвийн асуудлыг хасаад 7 асуудлаар хэлэлцэх асуудлыг баталъя. Санал хураалт явуулъя.

Тэгэхдээ бид түрүүлээд энэ чинь хурал зарлагдаад явчхаж байна шүү дээ. Яагаад гэвэл энэ чинь би бүр хэлэлцүүлэх гээд оруулж ирчхээд ямар сайндаа энэ асуудлаа хасах гэж байна шүү дээ.

Яагаад гэвэл төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэгдэж, эцэслэгдэж дуусаагүй байхад бид энд чинь тоо ярьж болохгүй байгаа байхгүй юу. Энэ яах аргагүй төсөв дагаад тоонууд ороод ирж байгаа байхгүй юу.

Түүнээс би үүнийг нь одоо бүр хэлэлцээд өгье гээд оруулж ирээд яг сая эцсийн моментод Байнгын хорооны ажлын хэсгээс надад үүнийг танилцуулж байна л даа. Үүнийг хасахгүй болболохгүй байна гээд.

Саяын томьёоллоороо санал хураая. Тэгээд төсвийн хүрээний

мэдэгдэл нь ороод ирэхээр нэгмөсөн хэлэлцье.

53 хувиар санал дэмжигдлээ.

Өнөөдөр энэ 4 байгууллагын Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон

Хүний эрхийн комиссын 2025 оны төсвийн төслийг хэлэлцэх асуудлыг төсвийн хүрээний мэдэгдэл эцэслэн шийдэгдтэл хойшлуулаад 7 асуудал хэлэлцэхээр шийдлээ.

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Нэг.Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай

Любляна-Гаагийн конвенцын төсөл

/Санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Нэгдүгээр асуудал, Засгийн газар 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зөвшилцөхөөр ирүүлсэн Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төсөл.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Ж.Соёлмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг танилцуулна.

Ажлын хэсгийн микрофоныг өгье 5 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Сайн байцгаана уу?

Эрхэм Байнгын хорооны дарга аа,

Эрхэм гишүүд ээ,

Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэг нь олон улсын эрүүгийн эрх зүйд хамгийн ноцтой гэмт хэргийн төрөлд тооцогддог.

Эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, гэмт этгээдийг шийтгэх, улс хоорондын эрх зүйн туслалцааны хамтын ажиллагааг сайжруулах, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх олон талт эрх зүйн баримт бичиг байгуулах ажлыг Монгол Улс 2017 оноос идэвхтэй дэмжиж ирсэн бөгөөд Бельги, Нидерланд, Славен, Аргентин, Сенегаль Улсын хамт конвенцын санаачилгыг урагшлуулах зорилготой үндсэн бүлгийн 7 гишүүн улсын нэгээр ажиллаж байна.

Үндсэн бүлгийн эдгээр гишүүн улсын төлөөлөгч нар Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсын хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төслийг боловсруулж, 2019 оноос эхлэн төслийн хэлэлцүүлгийг өрнүүлсэн.

Ийнхүү 2023 оны 05 дугаар сарын 15-наас 26-ны өдрүүдэд Любляна хотноо болсон Бага хурлаар конвенцын эх бичвэрийг баталсан юм.

Энэхүү конвенц нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц, Төрлөөр устгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц зэрэг уг салбарт хамаарах олон талт механизмууд байдаг хэдий ч төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэргийг хянан шийдвэрлэх зохицуулалтыг агуулсан анхны баримт бичиг болох юм.

Энэ ч хүрээнд уг санаачилгыг өдгөө 80 гаруй улс дэмжээд байна.

Тус конвенцод гарын үсэг зурах ёслолын арга хэмжээг Нидерландын Гааг хотноо 2024 оны 02 дугаар сарын 14-нөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 33 улс гарын үсэг зураад байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэгт заасны дагуу уг конвенцод гарын үсэг зурах асуудлыг зөвшилцөхөөр танилцуулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Д.Цогтбаатар: Төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү. Энэ дээр асуулт асууж болно.

Тэгэхээр төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Д.Ганбат гишүүнээр тасаллаа. Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Та бүхнийхээ амар амгаланг айлтгая.

Маш чухал конвенцод манай улс нэгдэж байгаа юм байна. 200-аад улс байгаа байх. Тэрний 180 нь нэгдсэн юм байна гэж ойлголоо.

Манай улс чинь одоо хэд дэх улс нь болж нэгдэх билээ?

Энэ олон төрлийн конвенцод бид нэгдэж байгаа. Манай Засгийн газар үүнийг сайн судалсан уу? Нэгэнт конвенцод нэгдсэн бол үүнийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр дагаж мөрдөж биелүүлэх үүрэгтэй. Яг дотоодын хуультайгаа адилхан ижил тэнцүү үйлчилнэ гэж ойлгож байна.

Бид чинь Үндсэн хуулиа ч хүртэл биелүүлдэг улсууд шүү дээ. Үндсэн хууль дээр иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр нь төр, засаг нь хангаж өгнө гэсэн ийм зүйл, заалт байгаа.

Гэтэл өнөөдөр Монгол Улс, Улаанбаатар, нийслэл, аймгийн төвүүд ямаршуухан байдалтай байгаа вэ гэдгийг бид мэдэж байгаа.

Хөрсний бохирдол, энэ агаар. Дээр нь нэмээд юугаар хийсэн нь мэдэгдэхгүй

түлш шатааж байгаа. Хэр олон хүн нас барсан бэ? Энэ чинь санаатай буюу санамсаргүйгээр устгах гээд заалт байна л даа. Энэ конвенцод.

Устгах гэж иргэдийн зарим хэсгийг устгах зорилгоор санаатайгаар амьдрах нөхцөл, тухайлбал хоол хүнс, эм тангаас тасалдуулахыг ойлгоно гэж байгаа.

Нэгдүгээрт, амьд амьсгалах агаар, энэ хортой агаараас болж хэчнээн хүн нас барсан байна.

Цаашид энэ маягаар үргэлжилбэл хэчнээн хүн нас барах вэ? Энэ конвенцод нэгдсэнээр олон улсын байгууллагад бид хандаж болох уу гэдэг ийм нэг асуулт байна.

Нөгөө талаар саяхан автобус унаагаараа ч хяхаж хавчиж байгаа байх. Тэрийг нь ч зөндөө цавчаа хийгээд авчихсан зүйл байгаа. Тэр сонсгол нь удахгүй явах гэж байгаа байх.

Нөгөө талаар эрүүл мэнд, эмийн хэрэгсэл, эм тангийн талаар сонсгол явсан.

Тэгээд ямар ч шаардлага хангахгүй эмийг удаан хугацаагаар монголын ард түмэн хэрэглэж ирсэн юм байна. Мөнгөө төлөөд. Стандарт бус, хуурамч эм хэрэглэдэг, үйлчилдэггүй эм хэрэглэдэг гэдгийг энэ сонсголоор хүлээн зөвшөөрсөн гэж ойлгосон.

Эрүүл мэндээс ч хохирсон байна. Үүнийхээ нөхөн төлбөр энэ юмыг одоо хэнээс, хаанаас нэхэмжилж авч болох вэ? Нэгэнт хохирсон иргэд нэхэмжилж авах эрхтэй гэж бодож байна.

Энэ зам байгаа. Өөрийн эд хөрөнгө, амь насаа Дархан

Улаанбаатарын замд бараг 300-аад хүн хохирсон гэж ойлгож байгаа. Амь насаа алдсан гэж бодож байна.

Тэр байтугай сая манай Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны эмэгтэй гишүүн ч замд бас явж байгаад амь насаараа хохирсон байна лээ.

Үүнээс гадна олон эмэгтэйчүүд ураг нь энэ агаараас болж, амьдрах орчноос болж амьгүй төрж байгаа ийм төрөлт сүүлийн үед ихэссэн гэж статистик хэлж байна.

Үүнийхээ дагуу бид энэ Засгийн газрыг олон улсын байгууллагууд энэ конвенцын дагуу өгч болох уу? Энэ эрх хангагдах уу гэсэн ийм асуулт надад байна.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгийн микрофоныг өгье. 5.

Б.Батцэцэг: Энэ санаачлахад нийтдээ Д.Ганбат гишүүн ээ, 80 гаруй улс дэмжиж байгаа юм.

Одоо өнөөдөр бид нөгөө нэгдэж орох асуудал биш, энэ гарын үсэг зурах асуудлыг хэлэлцүүлж байгаа.

Эхлээд гарын үсгээ зурна. Одоогоор 33 улс гарын үсгээ зурчихсан байгаа.

Тэгээд дараа нь нэгдэж орох асуудал бол дараагийн процесс явагдана. Б.Энхбаяр сайд нэмж хариулъя.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Сүүлийн үеийн гэмт хэргүүд нэг улс дотор хийгддэг биш болсон.

Манай улсын бараг 220, 230 мянган иргэн гадаад улсад зорчиж ажиллаж, амьдарч байна.

Ялангуяа мөнгө угаах, санхүүгийн авлига, албан тушаалын гэмт хэргүүд улс үндэстэн дамнаж хийгддэг болсон. Тийм ч учраас эдгээр улсуудтай хоёр талын хамтын ажиллагааны эрүүгийн эрх зүйн асуудал дээр хамтарч ажиллах гэрээ хэлэлцээрүүдийг байгуулах асуудал эцсийн үр дүндээ бид энэ нөхдүүдийн араас явж, нуугдсан хулгайлсан хөрөнгийг нь илрүүлж, баримтжуулж, ял зэмийг нь хүртээх ийм санаа хүсэл эрмэлзэлтэй шууд холбоотой байгаа юм.

Манай улс өнөөдрийн байдлаар 24 улстай байгуулсан 39 хоёр талт гэрээний үндсэн дээр ажиллаж байна.

Европын тухайтад Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцод Европын зөвлөлийн 48 гишүүн, Европын зөвлөлийн бус 5 улс нэгдэн орсон байдаг.

Энэ дотор манай улсын иргэд олноор аялдаг, суралцдаг, амьдардаг. Англи, Герман, Бельги, Голланд, Швед зэрэг улсууд багтаж байгаа.

Нийтдээ энэ 48 улсуудаас 18 орчим улстай нь манай улс одоо хоёр талын гэрээтэй байгаа.

Тэгэхээр энэ гэрээг байгуулчихвал бид нэмэх нь 28-аас 30 улстай эрүүгийн эрх зүйн чиглэлд хамтарч ажиллах боломжтой болно гэсэн үг. Өөрөөр хэлбэл Европын зөвлөлийн бүх улсуудтай хамтарч ажиллах бололцоотой болно гэсэн үг.

Хэдхэн жилийн өмнө авлигатай тэмцэх байгууллага.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Б.Энхбаяр: Авлигатай тэмцэх байгууллага Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн удирдах албан тушаалтан “Г” гэгч нь мөнгө угааж хууль бус аргаар олсон хөрөнгөө гадаад улсад, Европын Холбооны улсад байршуулаад хөрөнгө авсан асуудлыг илрүүлсэн.

Энэ асуудлыг тэр хөрөнгийг Монгол Улсад оруулж ирж хохирлыг Монгол Улсыг хохиролгүй болгох асуудлыг хоёрын талын хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжүүлсэн.

Хэрвээ энэ гэрээг бид одоо албажуулаад батлах юм бол энэ мэт олон хөрөнгө, олон нуугдмал юмнуудыг хоёр талын хууль хяналтын байгууллагууд хамтарч илрүүлж, эх оронд нь авчрах, холбогдох хүмүүст ял зэмийг нь хүртээх ийм эрх зүйн бололцоо бүрдэх юм гэж танд хариулья.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүнд тодруулах микрофон өгье.

Д.Ганбат: Бид гэрээ конвенцод нэгдэж байгаа юм чинь бас хариуцлагатай байх хэрэгтэй л дээ.

Тэгээд нэг юмыг би тодруулья. Насанд хүрээгүй эмэгтэй хүүхэдтэй. Манайх эрүүгийн хуулиар 14 нас гээд заачихсан байгаа байх.

Саяхан Сэлэнгэд, Говь-Алтайд цагдаа нар бэлгийн мөлжлөг, хүчингийн хэрэг хийсэн байна, Арван хэдэн наснаас нь эхлээд.

Энэ насанд хүрээгүй хүүхэд гэдгийг яг энэ конвенцод хэдэн наснаас нь оруулж байгаа юм бол?

Бусад улсуудын хуулиар 16 нас байгаа байх л даа. Тэгээд энэ хоёр ялгаатай байвал альныг нь дагаж мөрдөх юм?

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Энэ Европын конвенц л яриад байгаа юм. Уг нь.

Гэхдээ Ганбат гишүүний асуултад хариулъя.

Мэдээж бүх насаар хорих ялтай эрүүгийн тодорхой гэмт хэргийн асуудал асууж байгаа. Тодорхой гэмт хэргийг шалгах, мөрдөх асуудал хууль хяналтын байгууллагуудын хараат бусаар хийгддэг ажил. Энэ талын мэдээллийг прокурорын зөвшөөрөлтэйгөөр олон нийтэд мэдээлдэг.

Прокурорын зөвшөөрөлгүйгээр энэ асуудлыг хэн нэгэн мэдээлэх юм бол 1-ээс 5 жилийн хорих ялтай гэмт хэрэгт тооцогддог.

Тийм учраас тодорхой хэргийн асуудлаар Хууль зүйн сайд байр суурь мэдээж илэрхийлэх бололцоо байхгүй.

Харин нэг зүйлийг хэлчихье.

Тодорхой асуудлуудаар улс төрийн зорилготой хүүхдийн эрх ашигт эмзэг мэдээллийг улс төрийн зорилгоор худлаа түгээж байгаа асуудал байгаа.

Жишээлбэл, Говь-Алтай аймагт хүүхдийг бүлэглэж хүчиндсэн гэдэг мэдээллийг үгсэн хуйвалдаж, захиалга өгч мэдээллийг түгээсэн асуудал шалгагдаж байгаа.

Д.Цогтбаатар: Болсон уу? Ц.Мөнхцэцэг гишүүн асуух уу?

Би нэг юм асууя. Түрүүн Гадаад хэргийн сайд хэлж байна л даа.

Энэ “гэрээнд нэгдэж орохоор биш”, одоо “гарын үсэг зурах” асуудал яригдаж байна гээд.

Энэ чинь одоо юу гэсэн үг билээ?

Ер нь “гэрээнд гарын үсэг зурах” “зорилго” гэдэг чинь юу байдаг билээ? Нэгдүгээр асуулт.

Наадах чинь Гадаад хэргийн сайдын амнаас гарч байгаа. Бид орох гэж биш, зурах гэж Их Хурлаас зөвшөөрөл авч байна гэдэг чинь гаднынхан чинь сонсоод үүнийг юу гэж ойлгох вэ?

Хажууд чинь С.Сүхболд гээд хуульч хүн сууж байна.

“Intent” гэдэг бол аливаа “эрх зүйн акт” буюу “үйлдлийн” хамгийн гол хэсэг байдаг.

Дараагийн хийсэн үйлдлийг тайлбарлахад энэ маш чухал зүйл байдаг.

Ер нь энэ **intent**-ын тухай асуудал аль эрх зүйн эх сурвалжид заагдсан байдаг билээ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт нь, энэ чинь **jus cogens**¹-ийн тухай яриад байна л даа.

Тэгэхээр энэ “**Jus cogens**” гэдэг маань юу билээ? Хоёрдугаар асуудал.

Энэ конвенц “JUS COGENS”-г заагаагүй юуг зохицуулж байгаа

¹ **Jus cogens** [latin] гэдэг нь олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрөгдсөн татгалзахыг зөвшөөрдөггүй, заавал дагаж мөрдөх ёстой эрх зүйн хэм хэмжээ.

болохоор энд ингэж орж ирж байгаа билээ? Гуравдугаар асуудал.

Хэддүгээр микрофон гэнэ ээ? 6 юу? С.Сүхболд.

С.Сүхболд: Д.Цогтбаатар даргын асуултад хариулъя.

Энэхүү конвенц нь 3 процесс, бараг 4 процессыг илэрхийлж байгаа. Өөрөөр хэлбэл тодорхой хэмжээнд тухайн улс хүлээн зөвшөөрөх илэрхийллээ хангахаар байгаа.

Нэгдүгээрт, гарын үсэг зурах ийм боломжийг нээж өгсөн. Гарын үсэг зурснаараа цаашдаа энэхүү конвенцын үзэл санааг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах бэлтгэлийг хангуулах процессын эхлэлийг тавиулж өгч байгаа гэж ойлгож байгаа.

Гарын үсэг зурах нээлт 2025 оны 02 дугаар сарын 14-н хүртэл байгаа.

Үүнээс хойш соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсвэл нэгдэн орох процесс нээлттэй байгаа.

Учир нь яагаад гарын үсэг зурах асуудлыг зөвшилцөхөөр оруулж ирж байгаа вэ гэхээр энэхүү конвенцыг соёрхон батлахын тулд Монгол Улсын Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хуулиудыг нийцүүлэх ажиллагаа бас хийгдэх шаардлага байгаа гэж үзэж байгаа.

Тийм учраас энэ бэлтгэл хангагдахын тулд энэ зүйл хийгдэх болов уу гэж үзэж байгаа.

Энэхүү конвенцоор Монгол Улсын өмнө нь нэгдэж орсон олон талт гэрээгээр зохицуулж байгаа гэмт хэргийн

төрлийн эрх зүйн туслалцааг харилцан үзүүлэхээр зохицуулахаар байгаа. Тухайлбал, **“Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм”**-д заасан 4 төрлийн гэмт хэргийг

- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах,
- эрх зүйн туслалцаа үзүүлэх,
- гэрч, хохирогчийг хэрхэн хамгаалах,
- хамтарсан ажиллагааг яаж явуулах вэ

зэрэг нэлээн олон асуудлуудыг зохицуулж байгаа учраас үүнийг соёрхон батлахын тулд нэлээн бэлтгэл шаардлагатай юм байна гэж үзэж байгаа.

Энэхүү конвенцоор төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх зохицуулалт байгаа.

Өөрөөр хэлбэл олон улсын эрүүгийн эрх зүйн хүрээнд эрх зүйн туслалцаа үзүүлэх суурийг бэлтгэж өгөх ийм шаардлага байгаа.

Энэ конвенцод нэлээн олон зүйлүүдийг нарийвчилж тусгасан байгаа.

Тэгэхээр тухайлбал зүгээр онцлоод хэлэх юм бол энэ 3 төрлийн гэмт хэргийн зорилгоор олсон хууль бус орлогыг хураан авах, тэр гэмт хэргийн хохирогч болсон этгээдэд буцаан нөхөн төлбөр олгох ийм асуудлыг зохицуулж байгаа.

Тэгэхээр үүнийг бас манай дотоодын хуульдаа тусгаж өгөх зайлшгүй шаардлага байгаа.

Мэдээж энэ 3 төрлийн гэмт хэрэг дээр заасан зарим заалтууд.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Миний асуултад хариулмаар байна.

Гарын үсэг зурж байгаа энэ процессыг зохицуулж байгаа эх сурвалж, хууль чинь юу билээ?

С.Сүхболд: Олон улсын гэрээний тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу гарын үсэг зурах асуудлыг зөвшилцөхөөр оруулж ирж байгаа.

Д.Цогтбаатар: Өөрөөр хэлбэл наадах чинь олон улсын гэрээний тухай конвенцыг Монгол Улс нэгдэн орсон. Тэр дагуу манай хуулиуд гарсан байгаа шүү дээ.

Гол олон улсын эх сурвалж чинь “Олон улсын гэрээний тухай конвенц” байхгүй юу?

Тэгэхээр миний асуух гээд байгаа юм чинь та зурчхаад тэгээд одоо “ratification”² хийх эсэх нь тусдаа. Тэр угаасаа эрх зүйн хувьд тусдаа байдаг.

Үүнийг дагаад ямар үр дагавар үүсэж байгаа гэж Та бодож байна?

Наадах чинь яагаад гэвэл эргээд бид “ратификац” хийхгүй гэж бодоод зүгээр хэлбэр төдий гарын үсэг зурах гэж байгаа юм шиг асуудал сая Д.Ганбат гишүүний асуултад хариулчихлаа шүү дээ.

Би ийм асуулт асууя гэж бодоогүй байсан шүү. Орж ирж байгаа асуултад өгч байгаа хариулт чинь өөрөө ноцтой үр дагавар дагуулж байгаа байхгүй юу. Эрх зүйн хувьд.

Бид хууль ярьж байна шүү дээ. Зүгээр ийм “бла, бла” яриа биш.

Тэгэхээр одоо ингээд гарын үсэг зураад ямар үр дагавар гардаг билээ?

Хэн нь хариулах юм? Хэддүгээр микрофон өгөх вэ? 6 дугаар микрофон.

С.Сүхболд: Миний ойлгож байгаагаар манай хуулиар гарын үсэг. Би Д.Цогтбаатар гишүүний асуултыг ойлголоо.

Гарын үсэг зурснаараа манай улсын хуулиар “бүрэн мөрдөнө” гэдэг ойлголт одоогоор байхгүй.

Яагаад гэхээр Монгол Улсын Үндсэн хууль болон Олон улсын гэрээний тухай хууль дээр...

Д.Цогтбаатар: Би “мөрдөнө” гэж ерөөсөө асуугаагүй шүү дээ. Яагаад вэ. Би юу асууж байгаагаа ойлгоод байгаа болохоор асууж байна шүү дээ.

Тэгэхээр үүний дагуу ямар үр дагавар гарах билээ? 6 дугаар микрофон.

Та нар олон улсын гэрээ, конвенц авч орж ирж байгаа бол үүний дагуу ямар үр дагавар гарах вэ гэдгийгээ хариулж чадах ёстой шүү дээ.

С.Сүхболд: Уучлаарай. Би асуултыг нь нэг их сайн ойлгосонгүй.

Гэхдээ зүгээр миний ойлгосноор гарын үсэг зурснаар ямар эрх зүйн үүрэг хүлээх вэ гэж асуугаад байх шиг байна л даа. Тийм ээ.

Д.Цогтбаатар: Ямар эрх зүйн үүрэг хүлээх вэ гэж болно. Би тэгж асуулаа.

Ямар эрх зүйн үр дагавар гарах вэ гэдэг чинь ямар үүрэг хүлээх вэ гээд та

² “ratification” “Соёрхон батлах” гэдэг нь хууль, гэрээ, хэлэлцээрийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх, ихэвчлэн санал хураалтаар баталгаажуулах үйл явц, албан ёсны баталгаа.

тэгж орчуулж байна. Би таны орчуулгыг хүлээн зөвшөөрлөө.

С.Сүхболд: Олон улсын гэрээний тухай хуулиар Монгол Улсын Үндсэн хуулийн заалтаараа ч байсан гэсэн “Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон баталсан хууль хүчин төгөлдөр болмогц Монгол Улсын дотоодын хуулийн нэгэн адил үйлчилнэ.” гэсэн заалттай, ийм зарчимтай явж байгаа.

Тэгэхээр бидний ойлгож байгаагаар “энэ гэрээг соёрхон баталсны дараа Монгол Улс энэ гэрээнд хүлээсэн бүх үүргийг Монгол Улсын дотоодын хуулийн нэгэн адилаар хүлээнэ” гэж ойлгож байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Тэгэхээр яг л миний асуугаад байгаа асуулт. Та нар түүнд хариултаа мэдэхгүй үүнийгээ аваад ороод ирж байгаа байхгүй юу.

Тийм учраас үүнийгээ бид зурах гэж байгаа юм. Соёрхон батлах гээгүй гээд.

Цаана чинь сонсож байгаа 80 улс чинь юу гэж хүлээж авах вэ?

Их Хурал дээрээ та нар соёрхон батлах гээгүй юм бол яах гэж оруулж ирж байгаа юм?

Дараа нь оруулж ирчхээд соёрхон батлах гэж ийшээ авч орж ирэхгүй юм уу? Та нар.

Тэгээд юу яриад байгаа юм? Соёрхон батлах гээгүй. Бид зүгээр зурах гэж орж ирж байгаа юм.

Тэгээд та нар зурчихсаны дараа текстийг нь өөрчлөх гэж байгаа юм уу?

Текст чинь “парафированный”^[эхээрээ бичигдсэн] хийгдчихсэн. Өөрөөр хэлбэл initialing^[эхлэл] тавигдчихсанаас хойш текст өөрчлөгдөхгүй шүү дээ. Хэлэлцээд дуусчихсан байхгүй юу.

Монгол Улс наад “Гэрээний тухай олон улсын конвенц”-д чинь нэгдээд орчихсон байгаа.

Миний асуугаад байгаа үр дагавар. “Соёрхон батлах” хүртэлх хугацаанд гэрээний зорилготой нийцээгүй үйл ажиллагаа явуулж болохгүй болчхож байгаа юм.

Монгол Улс үүнийг “даган мөрдөнө” гэсэн үг.

Түүнээс энд орж ирчхээд бид зурах гэж байгаа, ратификац хийх гээгүй гэж ийм мэдэгдэл хийж орж ирж болохгүй шүү.

Хоёр дахь тэр асуудал jus cogens гэдэг чинь юу гэсэн үг билээ? Гадаад яам аа, jus cogens гэдэг чинь юу гэсэн үг билээ? 5 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Гарын үсэг зурсны дараа бид 4 процесстой гээд сая С.Сүхболд...

Д.Цогтбаатар: “JUS COGENS” гэж юу гэсэн үг билээ?

Б.Батцэцэг: Би тэрийг мэдэхгүй байна. Таныг яагаад уурлаад байгааг ерөөсөө ойлгохгүй байна.

Д.Цогтбаатар: Би уурлаагүй. Наадах чиний оруулж ирээд тавьж байгаа хариулт чинь ийм байгаа байхгүй юу.

Б.Батцэцэг: Үгүй үгүй. Та асуулт хариултыг мушгиад байна. Надад дургүйг чинь мэдэж байна.

Зүгээр, бид нар тайлбарлаад. 4 процесс байна. Эхлээд ингэж орчхоод дараа нь бид нэгдэж орохдоо дахиад орно оо гэж байна.

Д.Цогтбаатар: Үгүй.., Гадаад хэргийн сайд оруулж ирчихээд бид соёрхон батлах гээгүй гэж яриад суугаад байж болохгүй шүү дээ.

JUS COGENS. Би яагаад энэ асуултыг асуугаад байна гэхээр С.Сүхболд оо, чи бас мэдэж байгаа.

“JUS COGENS” гэдэг чинь “peremptory norm” [заавал дагаж мөрдөх хэм хэмжээ]. Өөрөөр хэлбэл, олон улсын, ёстой хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн тухай асуудал яригдаж байгаа юм.

Наадах чинь олон улсын угаасаа заншлаараа зохицуулагдаад явж байгаа.

Би тэгээд энэ конвенц дээр олон улсын заавал дагаж мөрдөх заншлаас давчихсан юу орж ирж байгаа билээ гэж би асуугаад байгаа юм.

Тэгэхээр тэрийг нь өөрөөр хэлбэл шинэ нормууд орж ирж байгаа болохоор энэ конвенц болж орж ирж байгаа юм бэ гэж би асуугаад байгаа юм.

6 дугаар микрофон.

С.Сүхболд: Олон улсын эрх зүйн зан заншлын хэм хэмжээгээр зохицуулж байгаа хэд хэдэн асуудлыг энэ конвенц дээр тусгасан байгаа.

Конвенцын 39 дүгээр зүйл.

Мөрдөн шалгах ажиллагааг явуулах 40 дүгээр зүйл.

Мөрдөн шалгах ажиллагааг “нууц ажиглалтаар хийх” асуудал байгаа.

42 дугаар зүйл дээр мөрдөн шалгах ажиллагааг хамтран ажлын хэсэг байгуулж хийх буюу аль нэг улсынхаа хүсэлт өгсөн улсын нутаг дэвсгэр дээр хамтарч дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу үйл ажиллагаа явуулах ийм үндсэн гурван зарчмыг энэ конвенц дотор тусгаж оруулж өгсөн нь өөр журам тогтоохоор байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, түрэмгийллийн эсрэг гэмт хэргийн зарим элементүүдийг хавсралтаар батлахаар хавсралтаар оруулж ирсэн энэ конвенцын учир нь түрэмгийллийн эсрэг гэмт хэргийн “Kampala Amendments” нэмэлт, өөрчлөлтөд 45 улс соёрхон баталсан.

Бусад орон нь хүлээн зөвшөөрөөгүй байгаа учраас бусад орнуудын онцлогийг харгалзаад энэхүү конвенцыг соёрхон батлахдаа энэ хавсралт гэмт хэргийн элементийг хүлээн зөвшөөрч, мөрдөн шалгах ажиллагааг явуулах уу, үгүй юугээ хүлээн зөвшөөрөх мэдэгдлийг гаргуулах эрхийг нь бас энэ конвенцоор өгсөн ийм 4 онцлог зүйл энэ дотор тусгагдаж орж ирсэн.

Бусад зүйлүүд ерөнхийдөө Монгол Улсын нэгдэн орсон бусад конвенцын хүрээнд заасан гэмт хэргүүд энэ төрөл дотор орж ирчихсэн байгаа.

Д.Цогтбаатар: Яг одоо үүнийг л би асуугаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл заншил болж төлөвшөөгүй байгаа олон улсын хуульд зохицуулалтад ороогүй байгаа нэмэлт заалтууд орж ирж байгаа бөгөөд энэ дотор сая чиний хэлсэн дээр нэмээд хамгийн гол нь хохирогчид дандаа орхигдчихсон байгаад байдаг байсан.

Хохирогчдын асуудал би нэмээд орж ирж байгаа. Энэ нь олон улсын гэрээт зохицуулалт болж орж ирж байна гэж ойлгож байгаа. Мөн үү? С.Сүхболд оо.

Тэр хохирогчдын талаар яг ямар заалтууд орж ирж байгаа юм? 6 дугаар микрофон.

С.Сүхболд: Би хохирогчийн заалтыг нь олоодохъя.

Хохирогчтой холбогдуулаад тусдаа заалтууд орж ирсэн. Түүрүүн би хэлсэн.

Нөхөн олговортой холбоотой буюу энэ 3 төрлийн гэмт хэргийг үйлдсэнээрээ олсон хууль бус орлогыг буцааж аваад хохирогчид нь өгөх тодорхой нөхцөлийг энэ зохицуулалтаар оруулж өгсөн байгаа.

81 дүгээр зүйл дээр хохирогчтой холбоотой бүхэл бүтэн бүлэг байгаа.

Хохирогч, гэрч болон бусад этгээдтэй холбоотой 6 дугаар бүлэг дээр энэ заалт оруулж өгсөн.

Хохирогч этгээдийг хамгаалахтай холбоотой зохицуулалтыг бас энэ конвенцоор тусгасан байгаа.

“Хохирогч” гэж ер нь хэнийг хэлэх вэ гэдгийг хүртэл энэ дээр зааж өгсөн байгаа.

Хохирогчийн эрх. Ийм зохион байгуулалтын асуудал.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Үг хэлэх гишүүн алга байна. Би үг хэлнэ.

Олон улсын гэрээ, конвенц, ялангуяа хүний эрхтэй холбогдсон. Түүн дотроо энэ “jus cogens” буюу “peremptory norm” хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгтэй холбогдсон ийм чухал конвенцыг авч орж ирж байж.

Нэгдүгээрт, энэ чинь аль эрт орж ирэх ёстой байсан. Маш удаж байж орж ирж байна.

Яагаад гэвэл одоо энэ чуулганаар энэ чинь уг нь соёрхон батлаад явчих ёстой байсан.

Та нар дэндүү удаж оруулж ирээд энэ чинь одоо соёрхон батлагдаж амжих уу, үгүй юу. Би тэрийг мэдэхгүй байна. Тэр нь ч одоо дүүрч.

Хоёрдугаар асуудал нь, энэ дээрээ техникийн асуудлуудаа маш сайн анхаарч мэдэж орж ирэх ёстой. Тэгэхгүй энэ дээрээ орж ирээд энэ чинь хамтраад нэгдээд орж байгаа энэ олон улсуудтай хүний эрхийн ийм чухал асуудлаар санал авч орж ирчхээд бид соёрхон батлах гээгүй байгаа. Одоохондоо гэсэн иймэрхүү санаатай юм яриад суугаад байж болохгүй. Наадах чинь тэгж сонсогдоод байсан байхгүй юу. Тэгээд би асууж байгаа юм.

Мэдээжийн хэрэг нэг ч удаа бид соёрхон батлах процедуртай. “Ad referendum”³ гэдэг юм. Наад гэрээг чинь.

“Ad referendum” гэрээг авч орж ирээд соёрхон батлаагүй үлдсэн нэг ч

³ “Ad referendum” гэдэг нь шийдвэр, зөвшилцөл, тогтоол нь эцсийнх биш гэдгийг илтгэх латин хэллэг бөгөөд дээд байгууллага, хороо, холбогдох байгууллагаас цаашид зөвшөөрөл авах, баталгаажуулахыг шаарддаг.

гэрээ байхгүй биз дээ? Бүгдийг нь соёрхон баталсан байгаа.

Яагаад гэвэл угаасаа цаад зорилго нь тэр. Эхнээсээ тийм зорилготой энэ чинь Их Хурлаар, процедураар орж гарын үсэг зурж явж байна шүү дээ. Эрхээ авч.

Тэгэхээр ийм чухал гэрээнүүдэд нэгдэж орж байгаа үедээ энэ юмнуудаа сайн судалж орж ирж бай. Тэр үүднээс нь хэлж байгаа.

Яагаад гэвэл дараа нь энэ чинь Монгол Улсад хууль болоод үг, үсгээрээ мөрдөгдөөд явна.

Наадхыг чинь мөрдөх явцад амаргүй асуудлууд гарч ирж болзошгүй. Өнөөгийн ертөнцөд. Тэр утгаар нь хэлж байгаа юм шүү.

Түүнээс ажил хэргийн юм ярихад асуудлаа бэлдэж орж ирчхээд хариу бариарай. Түүнээс Их Хурал дээр орж ирчхээд өөдөөс олон юм яриад, асуудлаа мэдэхгүй байж дуртай дургүй гээд хувийн асуудал яриад байж болохгүй шүү.

Монгол Улсын Их Хурал байна энэ чинь.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Люблина-Гаагийн конвенцын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

75.0 хувиар санал дэмжигдлээ.

Ц.Мөнхцэцэг гишүүн дэмжсэн байна. Дэмжсэн гэдэг тэмдэглэл оруулах нь зөв байх.

Конвенцын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин гишүүн уншиж танилцуулна.

Дараагийн асуудалдаа орё.

Хоёр.Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл

/Санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож

байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гадаад харилцааны яамны

Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Нарантуяа.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

Б.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын иргэд олноор зорчдог гадаад улстай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсаас Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын 1959 оны конвенцод нэгдэн орох тухай хүсэлтийг Европын Зөвлөлийн Сайд нарын хороонд гаргаж, тус хороо нь орлогч сайд нарын 2019 оны 13, 63 дугаар хурлаар хэлэлцэн дэмжээд урилга ирүүлсэн болно.

Монгол Улс гадаадын 24 улстай байгуулсан 39 хоёр талт гэрээний үндсэн дээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэмт этгээд ялтан шилжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн байна.

Үүнд ихэнх нь Зүүн Европ болон Азийн улсууд багтаж байна.

Харин Баруун Европын ихэнх улстай олон улсын конвенцуудад заасан тодорхой төрлийн гэмт хэргээс бусад гэмт хэргийн асуудлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх асуудлаар харилцах боломжгүй байна.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцод Европын зөвлөлийн 48 гишүүн улс, Европын зөвлөлийн гишүүн бус 5 улс нэгдэн орсон бөгөөд тус конвенцын гишүүн улсын тоонд Монгол Улсын иргэд суралцах, ажиллах, бизнес болон аяллын зорилгоор олноор зорчдог, оршин суудаг Англи, Герман, Бельги, Ирланд, Швед зэрэг улсууд багтаж байна.

Энэхүү конвенцод нэгдэн орсноор манай улсын хуулийн байгууллагууд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой зарим ажиллагааг, тухайлбал, нотлох баримт албажуулж авах, мөрдөн шалгах ажиллагаанд холбогдох этгээдийг байлцуулах, гэмт хэргийн улмаас олдсон эд зүйл, хэрэгслийг хураан авах зэрэг тодорхой төрлийн ажиллагааг конвенцын гишүүн улсуудын нутаг дэвсгэрт гүйцэтгүүлж, туслалцаа авах боломжтой болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу энэхүү конвенц нь заавал соёрхон батлах олон улсын гэрээ бөгөөд 10 дугаар зүйлийн 10.4 дэх заалтад заасны дагуу түүнд гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон улсын олон талт гэрээ тул Засгийн газрын хуралдаанаар тус конвенцод нэгдэн орох саналыг хэлэлцүүлэхдээ түүнийг Соёрхон батлах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хамт хэлэлцүүлсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг

соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хороонд танилцуулж байна.

Хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Ц.Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг Улсын Их Хурал соёрхон батлах нь зүйтэй.

Ер нь Монгол Улсын тодорхой албан тушаалтан авлигын гэмт хэрэг хийчхээд, эсвэл тодорхой хэрэг үүсээд эхлэнгүүт өвчтэй гэдэг юм уу, эмчлүүлэх гэдэг юм уу, ямар нэгэн шалтгаанаар оргон зайлсан асуудал нэлээд байгаа.

Дээр нь Монгол Улсын төрийн тэргүүн байсан тодорхой улс төрчидтэй холбоотой мэдээлэл гараад байгаа шүү дээ. Нөхдүүдэд хилийн чанадад гараад явчихсан.

Тэгээд энэ тохиолдолд хэрвээ тухайн улстай нь Монгол Улс эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээгүй учраас яг мөрдөн байцаах гэдэг юм уу, тодорхой шүүхийн үйл ажиллагаа явуулах боломжгүй байгаа.

Тэгэхээр бид аль болох олон улстай эрүүгийн эрх зүйн, бусад харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах нь зүйтэй байгаа.

Тэгэхээр Европын конвенцод бид нэгдсэнээр нийтдээ Европын холбооны 48, дээр нь бүсийн бус 5 гээд 53 улстай яг

эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, яллагдагчдыг дуудан ирүүлэх гэх мэт бүх процесс нээлттэй болж байгаа юу гэдгийг асууя.

Хоёрдугаарт нь, түрүүн дурдсан. Гадаадад оргон зайлчихсан авлигын эсрэг гэмт хэрэгтнүүд, нэр бүхий хүмүүс байна. Жишээлбэл, олон нийтийн мэдээллээр мэдэж байгаагаар нь Ерөнхий сайд байсан Ч.Сайханбилэг, бас Монголбанкны Ерөнхийлөгч байсан Н.Баяртсайхан ч гэдэг юм уу. Эд нарын авлигатай холбоотой мэдээллүүд байгаа ч Монгол Улсад иргэн авчирч “Шувуу” ажиллагааны хүрээнд шударга шүүхийн үйл ажиллагаа явуулах боломжгүй байна.

Тэгэхээр энэ оргон зайлсан этгээдүүдийг эргэн авах энэ “Шувуу” ажиллагаа маань ер нь ямаршуу явцтай байгаа вэ? Хэдэн этгээдүүдийг авчирч байна.

“Шувуу” ажиллагаа буюу оргон зайлсан гэмт хэрэгтнүүдийг авчрахад ер нь эрх зүйн цаашид ямар шинэ хууль гэдэг юм уу, шинэ дэмжлэг хэрэгтэй байгаа вэ гэдгийг Хууль зүйн сайдаас асууя.

Яг адилхан **“Таван Ш”** ажиллагааны нэг болох шүүхийн шийдвэрээр эргэн төлүүлэх буюу нөгөө оргон зайлсан этгээдүүд маань гадаадад байршуулчихсан хөрөнгүүдийг буцаан авах, шилжүүлэх үйл ажиллагаа маань бас яаж явж байна аа?

Энэ шилжүүлэх үйл ажиллагааны хүрээнд ер нь гадаадад оффшорт нуучихсан байгаа тодорхой авлигын гэмт хэргийн үндсэн дээр бий болсон хэдий тооны хөрөнгө Монгол Улсад эргэн

ирсэн байгаа вэ гэдгийг сайдаас бас тодруулья.

Д.Цогтбаатар: Нэн хариулах вэ? Тийм. “Шувуу” ажиллагаа. Тийм. Шилжүүлэн авах. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: “Шувуу” ажиллагаа их амжилттай явж байгаа.

Ер нь эрэн сурвалжилж байсан, гадагшаа оргон зайлчихсан нөхдүүдийг бид 70-аас 75 хувьтай авчирчхаад байгаа.

Энэ их амжилттай явж байгаа. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тухайтад энэ ажиллагааг дэмжиж хөрөнгө санхүүгийн хувьд. Энэ бас нэлээн өртөгтэй зардал гарч байгаа.

Үүнийг бүх талаар дэмжиж ажиллаж байгаа.

Хамгийн сүүлд гэхэд бусдын амь насанд халдах, захиалгаар халдсан, энэ асуудал нь шалгагдаж байхад оргон зайлсан этгээдийг олж авчирсан байгаа.

Та сая Монголбанкны Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Н.Баяртсайханыг эрэн сурвалжилж байгаа гэж. Надад тийм мэдээлэл байхгүй байгаа.

Н.Баяртсайхан Ерөнхийлөгчийг ямар нэгэн эрүүгийн хэрэг үүсгэж, шалгаж байгаа асуудал байхгүй гэж би бодож байна.

Н.Золжаргалтай харин андуурсан байж магадгүй. Тийм. Н.Золжаргал дээр харин Австри Улс шиг санаж байна. Үл хөдлөх хөрөнгө худалдаж авсан асуудал хоёр талын хууль хяналтын байгууллагуудын хүрээнд шалгагдаж,

шүүхээр хянан шийдвэрлэгдсэн асуудал харин байгаа.

Ч.Сайханбилэгийн тухайтад Америкийн Нэгдсэн Улстай манай улс хоёр талд эрүүгийн эрх зүйн салбарт хамтарч ажиллах гэрээ хэлэлцээр байхгүй байгаа.

Дипломат шугамаар энэ асуудал хууль хяналтын байгууллагын түвшинд байнга явагдаж байгаа. Ч.Сайханбилэгийг хаана байгаа гэдгийг бид мэдэж байгаа. Ч.Сайханбилэг бийлэгжүү байгаа. Монголоос мөнгө орж, гарч байгаа. Холбоо сүлбээтнүүд нь хэвээр байгаа.

Тэгэхээр энэ асуудал бас хууль хяналтын байгууллагаар шалгагдаж явж байгаа.

Д.Цогтбаатар: Тодруулах уу? Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Түрүүн нэр дээр андуурсан байна шүү.

Монголбанкны Ерөнхийлөгч асан Н.Золжаргал байсан.

Тэгээд энэ шилжүүлэн авах ажиллагааны хүрээнд яг хэд орчим төгрөгийн гэмт хэргийн аргаар гэдэг юм уу, авлигын аргаар оффшорт нуун гаргасан хөрөнгүүд ер нь орж ирж байгаа вэ?

Шилжүүлэн авах үйл ажиллагаа маань хэр явцтай байгаа гэдгийг тодруулан асууя.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Тэгвэл микрофонд наадхаа хэлчих дээ. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Яг энэ “Шувуу” ажиллагаа эхэлж байх үед Интерполын улаан булант зард 22, хөх булант зард 70, нийтдээ 92 этгээд эрэн сурвалжлагдаж байсан.

2024 оны 02 сарын 14-ний байдлаар буюу “Шувуу” ажиллагаа хэрэгжсэн нэг жилийн хугацаанд Интерполын улаан булант /”Red Notices”/ зард 5, хөх булант /”Blue Notice”/ зард 52, нийт 57 иргэнийг олж тогтоочихсон байгаа.

Мөрдөн шалгах чиг үүргийн байгууллагаас олж тогтоож авчирсан 13, сайн дураараа хэргээ шийдвэрлүүлэхээр ирсэн 14 иргэнд мөрдөн шалгах ажиллагаа явагдаж, 4 иргэний хэрэг шүүхэд шийдвэрлэгдсэн байдалтай байна.

2023 оны 3 сараас хойш буюу өнгөрсөн энэ “Шувуу” ажиллагаа хэрэгжсэн нэг жилийн хугацаанд гадаад улсад байгаа 30 иргэний гадаад пассын бүртгэлийг хүчингүй болгосон байгаа.

Өөрөөр хэлбэл тэр хүмүүсийн гадаадад зорчих, амьдрах боломжийг хязгаарласан байна.

Д.Цогтбаатар: Болсон уу? Ц.Мөнхцэцэг гишүүн.

Тэгвэл асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алга байна.

Би үг хэлнэ.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах нь үнэхээр чухал.

Сая Ц.Мөнхцэцэг гишүүний яриад байгаа асуудлууд ч гэсэн маш чухал байгаа. Ялангуяа Европын холбоотой манай зүгээс харьцахад манайх нөгөө хүний эрхийн хууль тогтоомжууд, Европын холбооны хууль тогтоомжуудтай хэр уялддагаас хамаараад аливаа асуудал дээр хамтран ажиллахад хүндрэл гардаг байсан.

Ялангуяа нээрээ тэнд байгаа, эсвэл тийшээ зугтаад гарчихсан ч юм уу иргэнийгээ буцаагаад авчирна гэдэг дээр танай улсын хүний эрхийн хуулийн нөхцөл байдал, хэрэгжилт эргэлзээтэй байгаа тул манайд байгаа хуулийн дагуу шийдэгдэх асуудлаас давсан ял өгөх, эсвэл жишээлбэл хуучин цаазын ялтай байхад бүр хүн гаргаж авах маш хэцүү байдаг байсан.

Тэгэхээр одоо энэ ингээд соёрхон батлагдсанаараа энэ үүд хаалгууд харьцангуй нээгдэнэ. Харьцангуй шүү бас. Яагаад гэвэл улс орон болгон өөрийн эрх зүйн хүрээнд болон өөрийнхөө хууль тогтоомжийн хүрээнд манайтай энэ асуудал дээр харьцах учраас. Ялангуяа эрүүгийн асуудал дээр энэ нарийн зохицуулалттай.

Тэгэхдээ ямар ч гэсэн энэ нэлээн том үүд хаалгыг нээж өгч, манай хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны царааг тэлж өгч байгаа юм.

Энэ утгаараа харин үүнийгээ хэрэгжүүлэх дээр нэлээн бодитой анхаарч ажиллах ёстой.

Энэ чиглэлээр Европын орнуудтай Б.Энхбаяр сайд аа, бас харилцан яг энэ хүний эрхийн асуудлаар, энэ Эрүүгийн хуулийнх нь асуудлаар хамтарсан сургалт Монголдоо хийх. Бас хүмүүсээ энэ чиглэлээр нь бэлдэх ийм хэрэгцээ гарах байх шүү.

Үүнийгээ эртхэн Европын Холбооны дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулаад бас ярьж байгаарай.

Яагаад гэвэл эцсийн дүндээ яг хэрэгжүүлэх дээрээ тулаад ирэхээр хүмүүс маань энэ хэмжээний мэдлэггүй, сургалтгүй байгаа болохоор хуульд байгаа боломжуудаа гүйцэд ашиглахгүй байх ийм сул тал ажиглагдаж байдаг болохоор үүнийг анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулж эхэлье.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

81.8 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд Ц.Мөнхцэцэг гишүүн танилцуулчих уу.

Ц.Сэргэлэн генерал танилцуулчихъя.

Санал, дүгнэлтийг Гадаад бодлогын байнгын хороон дээр. Тийм. Тэгье.

Дараагийн асуудалдаа орёе.

**Гурав.Шүүх байгуулах тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Засгийн газар 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг

ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулна.

Г.Амартүвшин: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор Шүүх байгуулах тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшинөөр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд ажлын дэд хэсэг 4 удаа, ажлын хэсэг 3 удаа тус тус хуралдлаа.

Ажлын хэсгээс уг хуулийн төсөлд дараах өөрчлөлтийг оруулахаар санал оруулж байна. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын шүүхийн тухай хуулиар давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болохоор хуульчилсан боловч Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр баталгаажсан хүний үндсэн эрхийг хангах, хамгаалах хүрээнд давж заалдах шатны шүүхийн одоогийн тогтолцоо байрших газрыг хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзлээ.

Шүүх байгуулах тухай хууль шинэчилсэн найруулгын төслийн дагаж мөрдөх хугацааны талаар өөрчлөн зохион

байгуулагдаагүй 21 аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, нийслэлийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, сум дахь сум дундын 8 шүүх, Багануур дүүргийн эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхийг байгуулах зохицуулалтыг ердийн журмаар, аймаг дахь сум дундын анхан шатны шүүх, дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны шүүх, дүүргийн эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүх, Багахангай, Налайх дүүргийн эрүү, иргэний анхан шатны тойргийн шүүхийн шүүхийг байгуулах зохицуулалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр, гэр бүл хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийг байгуулах зохицуулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тус тус тусгалаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн авлигын хэргийг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, хяналтын шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэх талаарх зохицуулалтыг хуулийн төслөөс хасахаар тусгалаа.

Шүүх байгуулах тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар 26 зарчмын зөрүүтэй саналын томъёололыг бэлтгэсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Шүүх байгуулах тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга, зарчмын

зөрүүтэй саналын томъёололыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Шүүхийн сахилгын хорооны гишүүн С.Энхтөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Ш.Цолмон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль тогтоомжийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Б.Болд, Нээлттэй нийгэм форумын менежер П.Бадамрагчаа гэсэн төлөөлөл энэ ажлын хэсэгт орсон байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье.

Хоёр саналтай байгаа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 7, 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7, 8, 13, 14 дахь заалт болгох:

Та нарт материал тараагдсан байгаа. Таблиц орж ирж байгаа.

7.Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Дархан-Уул аймаг, Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж;

8.Дархан-Уул аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дархан-Уул аймаг, Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж,

13.Орхон аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Орхон аймаг, Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж,

14.Орхон аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Орхон аймаг, Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Саяын уншиж танилцуулсан 1 дүгээр зүйлийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

72.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 22, 23 дахь заалтын “тойргийн” гэснийг хасах.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

54.5 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

3.Хуулийн төслийн 2 дугаар зүйл. Н.Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Б.Энхбаяр гишүүн асуух юм уу? Зүйл бүрээр бид хэлэлцээд л явж байна. Одоо яг 2 дээрээ явж байна. Н.Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Манай ажлын хэсэг оруулж ирсэн. Нөгөө засагтайгаа ойлголцсон байх гэж бодоод би дэмжээд байгаа юм шүү.

Ер нь хэдүүлээ дэмжээд хурдан явуулах ёстой байгаа юм. Надад ийм хоёр эргэлзээтэй зүйл байгаа юм.

Нэгдүгээрт, энэ бүсчилсэн гээд байгаа юмтай чинь тойрогийн чинь юм ер нь ямар нэгэн уялдаа холбоо корреляцтай юм байна уу, байхгүй явна уу? Нэгдүгээр асуулт шүү.

Хоёрдугаарт, бид хүнийг цагдан хорих зөвшөөрөл өгдөг юмыг тусгай маягийн шүүх байгуулж байгаад хийе гээд нэг хууль саяхан батлаад намраас ч билүү хэрэгжихээр явуулсан шүү дээ.

Тэгээд тэр маань хойшилчих гээд байна уу, эсвэл одоо энэ та нарын оруулж

ирж байгаагаар болчих гээд байна уу? Ийм хоёр юманд хариулт авмаар байна.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хариулах уу? Г.Амартүвшин гишүүн хариулах уу? Г.Амартүвшин гишүүн хариулаад. Тэгээд нэмэх хэрэгтэй бол ажлын хэсэг хариулна биз. Г.Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Н.Алтанхуяг гишүүний асуултад хариулья.

Бүсчилсэн хэлбэрээр шүүхийг зохион байгуулах асуудал. Энэ нь анхан шатны шүүхийн асуудлыг бид оруулсан байгаа. Өөрөөр хэлбэл Нийслэлийн анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулна.

Харин давах шатны шүүхийг. Өргөн барьсан төсөл дээрээ зөвхөн Дархан, Эрдэнэт хотын давах шатны шүүхийг оруулж ирсэн байсныг бид тэрийг нь энэ хэлэлцэж байгаа төслөөсөө хасаад, нэгмөсөн давах шатны шүүхийнхээ үзэл баримтлал болон шинэ төслийг 2024 ондоо багтаад Их Хуралд өргөн мэдүүлэх тийм чиглэлийг дагалдаж байгаа тогтоолдоо оруулсан байгаа.

Тийм болохоор өөрийн чинь яриад байгаа тэр тодорхой хэмжээний тойргоор зохион байгуулах шүүхийн асуудлыг оруулсан.

Хоёр дахь асуудал нь, хялбар ажиллагааны шүүх болон гэр бүлийн шүүхийг энэ хуулиараа бас зохицуулж байгаа.

Өөрөөр хэлбэл таны саяын дурдсан цагдан хорих болон тэр асуудлыг бид энэ хуулиараа бас зохицуулахаар оруулсан байгаа.

Манай ажлын хэсгийн дэд хэсгийн гишүүд нэмж хариулбал хариулаарай.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон өгье.

Л.Энхбилэг: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Н.Алтанхуяг гишүүний асуултад хариулья.

Анхан шат дээр бид нийслэлийн анхан шатны шүүхүүдийг тойрогжуулж байгаа. Өөрөөр хэлбэл баруун, зүүн талдаа 3, 3-аар нь эрүү, иргэнээр нь дагнаж.

Орон нутагт бид дагнасан шүүхүүд явж байгаа. Үүнийгээ орон нутагт аймагт ердийн буюу эрүү, иргэнийг дотроо танхимтай байх төсөөлөлтэйгөөр ердийн шүүхээр аймаг аймагт нь байршуулж байгаа.

Алслагдсан дүүрэг буюу Багануур дагнасан шүүхээр явж байгаа. Налайх, Багахангай дүүргийг тойрогжуулаад эрүү, иргэнээр нь бас дагнасан шүүхээр явуулж байгаа.

Цагдан хориотой холбоотой асуудал бол “хялбар ажиллагааны шүүх” гэж нийслэлд тойрогжуулж хялбар ажиллагааны эрүү, иргэний анхан шатны тойргийн шүүх гэж.

Орон нутагт ердийн шүүх нь харьяалуулаад шийдвэрлэхээр төсөлд тусгагдаад явж байгаа.

Д.Цогтбаатар: Асуулт хангалттай юу? Н.Алтанхуяг гишүүн ээ.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Танилцуулья. Үүгээр санал хураалт явуулья.

3.Төслийн 2 дугаар зүйлийн Нэг, Хоёр дахь хэсгийн 3 дахь заалтын “Улаанбаатар хот” гэснийг “Улаанбаатар хотын Налайх дүүрэг” гэж, Нэг, Хоёр дахь хэсгийн 4 дэх заалтын “Улаанбаатар хот” гэснийг “Улаанбаатар хотын Багануур дүүрэг” гэж, мөн зүйлийн Гурав, Дөрөв дэх хэсгийн “Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэснийг “Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Энэ томьёоллоор санал хураалт явуулья. /алх цохив/

72.7 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын шинжтэй нэг санал байгаа.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаар, ишлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан “Ажлын хэсэг”

Санал хураалт явуулья. /алх цохив/

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Шүүх байгуулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн санал байхгүй байгаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. Нэг санал байгаа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хэрэг, маргааныг” гэснийг “эрүү, иргэний хэрэг, маргаан, эрүүгийн хэргийн шүүх харьяаллын шийдвэрлэх зөрчлийн хэрэг маргааныг” гэж өөрчлөх.

Санал гаргасан “Ажлын хэсэг”.
Санал хураалт явуулъя. /алх цохив/

72.7 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн санал байгаа юм байна. Би тэрийг уншиж танилцуулъя.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “20... оны дүгээр/дугаар сарын ... -ны өдрийн дотор” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор” гэж өөрчлөх.

Санал гаргасан “Ажлын хэсэг”.
Санал хураалт явуулъя. /алх цохив/

72.7 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга”-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсэгт заасан анхан болон давж заалдах шатны шүүхэд шүүгчийг томилуулах тухай саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

Санал гаргасан “Ажлын хэсэг”.
Санал хураалт явуулъя. /алх цохив/

80.0 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт, Хоёр дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалт, мөн зүйлийн Гурав, Зургаа дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан “Ажлын хэсэг”.
Санал хураалт явуулъя. /алх цохив/

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хууль Шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын шүүхийн тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Б.Энхбаяр гишүүн байна.
Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Шүүх байгуулах тухай хуулийг дагалдуулж Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэдэн асуудлыг Засгийн газраас оруулж ирсэн юм.

Засгийн газраас өргөн барьсан 3 асуудлыг хасахаар ажлын хэсгээс оруулж ирсэн юм байна.

Нэгдүгээрт, бид Үндсэн хуульд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хороог байгуулсан.

Ингэхдээ шүүхээс 5 хүн орж байгаа. Энэ Үндсэн хуулийн байгууллагад.

Тэр дотроо Улсын дээд шүүхээс Шүүхийн ерөнхий зөвлөлд 1 хүн, Шүүхийн сахилгын хороонд Улсын дээд шүүхээс 1 шүүгч томилогдож байгаа.

Энэ Үндсэн хуулийн байгууллагад томилогдсон тэр шүүгч маань 4 жилийн хугацаатай болон 6 жилийн хугацаатай өөр байгууллагад томилогдчихож байгаа юм. Үндсэн хуулийн.

Шүүхээ хянадаг тийм байгууллагад томилогдчихож байгаа юм.

Тэгэнгүүт өнгөрсөн Шүүхийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн 3 жилийн хугацаанд нөгөө Улсын дээд шүүхийн шүүгч байж байгаад Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн болсон, Улсын дээд шүүхийн шүүгч байж байгаад Шүүхийн сахилгын хорооны гишүүн болсон шүүгчийн орон тоог нөхөхгүй байгаа юм.

Өөрөөр хэлбэл Шүүхийн ерөнхий зөвлөл тэр нэг орон тоог нь зарлахгүй байгаа юм.

Яагаад гэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч 5 гишүүн нь энэ саналыг дэмжихгүй байгаа.

Нөгөө Дээд шүүхийнхээ Шүүхийн ерөнхий зөвлөл юм уу, Сахилгын хороонд байсан хүний нөлөөгөөр.

Тэр Улсын дээд шүүхийн шүүгч байж байгаад Шүүхийн сахилгын хороонд оччихсон хүн өөрийнхөө сул орон тоог зарлуулахгүй байлгаад байгаа байхгүй юу. Өөр байгууллагад томилогдчихоод. Үндсэн хуулийн.

Та бүхэн бод л доо 6 жилийн хугацаагаар Улсын Их Хурлаас Үндсэн хуульд заачихсан өөр байгууллагад томилогдчихоод өөрийнхөө нөгөө ажиллаж байсан Дээд шүүхийнхээ орон тоог зарлуулахгүй хэвээр хадгалуулаад байгаа байхгүй юу.

Үүнээс болоод Монгол Улсын Дээд шүүх 2 орон тоо дутуу яваад байгаа юм. Ачаалал нь нэмэгдээд байна.

Яагаад гэхээр шүүхийн хуульд зааснаар танхим чинь 8 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хуралддаг. Тэгэнгүүт 2 шүүгчийнх нь орон тоог нь Шүүхийн ерөнхий зөвлөл зарлахгүй. Яагаад зарладаггүй юм бэ гээд асуугаад байхаар нөгөө өөрөө зарлуулахгүй байгаа байхгүй юу. Өөрийнхөө орон тоог. Ийм байж болдог юм уу?

Тэгээд эс үйлдэл хийгээд байхаар нь арга буюу хууль дээр нь бичсэн байхгүй юу.

Дээд шүүхээс томилогдчихсон тэр хүний чинь орон тоог сонгон шалгаруулж томилох, зарлаач ээ гээд.

Монгол Улсын Дээд шүүх чинь одоо бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллах ёстой шүү дээ. 4 жил, 6 жилийн өөр байгууллагад томилогдчихсон хүний орон тоог яахаараа 6 жил хадгалаад байж байх ёстой юм. Нөгөө шүүгч нар нь зохиомол ачаалал аваад.

Тэгээд үүнийг нь хууль дээр нь бичиж өгье. Шүүхийн ерөнхий зөвлөл бүр үүрэгжүүлье гэдэг заалт оруулсан байхгүй юу. Тэгсэн тэрийг нь хасахаар одоо орж ирээд байна л даа.

Тийм учраас би гишүүдээсээ үүнийг ажлын хэсгийн тэр нэг дэх санал, хасах саналыг нь дэмжихгүй төслийнх нь заалтаар үлдээчхээч ээ гэсэн ийм хүсэлтэй байгаа юм.

Д.Цогтбаатар: Шүүхийн тухай хууль яриад. Энэ чинь саналгүй байгаа шүү дээ. Сайд аа. Тийм. Энд өөр та юутай андуураад л байх шиг байна.

Дараагийнх дээр нь яригдах юм. Тийм. Яг тэр дарааллаараа л явж байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналгүй.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Сая Б.Энхбаяр гишүүний саналыг. Тэгвэл гишүүд Б.Энхбаяр гишүүний

саналыг бас өөрсдөө. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Би сая Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр нэгэнтээ томилогдсон Улсын Дээд шүүхийн шүүгчийн орон тоог хадгалаад сул орон тоог нь зарлахгүй байгаа хууль бус Шүүхийн ерөнхий зөвлөлийн эс үйлдлийн тухай асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөлийг дийлэхээ болиод арга буюу хуулиар нь бүр хадаж өгч, ойлгомжтой болгоё гэж оруулж ирсэн заалтынхаа тухай үг хэлсэн.

Энэ Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд бас нэг зарчмын саналыг Монгол Улсын Ерөнхий сайд оруулж ирж байгаа.

Энэ нь юу байна вэ гэхээр ер нь энэ шүүгчдийн цалинг Улсын Их Хурал тогтоож явж ирсэн.

Одоо шүүгчдийн цалинг хамгийн сүүлд хэдэн онд тогтоосон? Их Хурлын тогтоолыг барьж байгаа юм? Хэдэн онд? Аан.

Улсын Их Хурал тогтоож байгаа энэ асуудал дээр хэд хэдэн зарчмын асуудлыг ярьсан юм.

Тэр нь Монгол Улсын Үндсэн хууль ёсоор Улсын Их Хурал бол хууль тогтоох эрх мэдэл.

Улсын Их Хурал өөрийнхөө цалинг өөрөө тогтоож явж байгаа. Өөрөө тогтоодог.

Гүйцэтгэх эрх мэдэл. Засгийн газар. Засгийн газар өөрийнхөө цалинг бас өөрөө тогтоож явж байна.

Шүүх эрх мэдэл. Шүүх эрх мэдлийн цалинг шүүх нь өөрөө мэддэггүй.

Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн барьцаанд байна. Барьцаанд байна.

Шүүгчийн цалин дээр аягүй их улс төр хийж байна.

Бусад байгууллагын цалин ямар нэгэн байдлаар инфляцуудаа дагаад нэмэгдээд байдаг. Шүүхийн цалин болохоор Улсын Их Хурлаас тусдаа тогтоолоор батлагддаг.

Тэгээд улс төрчид нь ч айдаг юм уу, шүүх нь ч хөөцөлддөггүй юм уу, арваад жил хөдлөхгүй явж ирсэн. Тэгээд сүүлдээ мөрдөх байгууллагуудаасаа доор цалинтай болчихсон. Монгол Улсын одоо нөгөө хараат бус шүүх эрх мэдэл нь.

Тийм учраас хаашдаа улсын төсвийг Засгийн газрын өргөн барьснаар Улсын Их Хурал баталж байгаа.

Энэ хүрээндээ тухайн орон тоо, цалингийн санг нь угаасаа төсвийн хуулиараа Улсын Их Хурал батлаад байгаа юм.

Харин дутуу орон тоогоор маш их ажилладаг юм байна. Шүүх. Төрдөг, чөлөө авдаг, өвддөг. Тэр хэмнэгдэж байгаа цалингийн сан дотроо нэг шүүгч өвдөхөд тэр шүүгчийн чинь ачаалал нь нөгөө цөөхөн ажиллаж байгаа 4, 5 шүүгч дээрээ өндөр ачаалал болж ирдэг.

Шүүгч нар нэгийгээ битгий өвдөөсэй гэж залбирдаг. Битгий чөлөө аваасай гэж боддог. Яагаад гэхээр нэг шүүгч өвдөхөд нөгөө хэд өөр дээр нь

шууд маш их ачаалал хүрээд ирдэг. Нөгөө хэргийг нь хуваадаг учраас.

Тийм учраас энэ цалингийн санд нь багтаагаад нэгэнт Улсын Их Хурлаас баталсан цалингийн сандаа багтаагаад тэр цалингийнхаа нэмэгдлийг заавал Улсын Их Хурлаар орохгүйгээр Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө шийдээд явж байг гэдэг өөрчлөлтийг оруулж ирсэн юм.

Үүнийг нь хасахаар ажлын хэсгээс орчихжээ.

Энэ дахиад Улсын Их Хурал Засгийн газрынхаан барьцаанд хамааралтай хэвээр байна.

Яахаараа Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Сангийн сайдын үүдэнд царай алдаад сууж байх ёстой юм бэ. Шүүгч нар цалин гуйгаад сууж байх ёстой юм бэ.

Хаашдаа Улсын Их Хурал цалингийн санг нь баталчхаж байгаа байхгүй юу. Одоо нийт Монгол Улсын 560 шүүгчийн цалин тэд гээд баталчихсан байгаа байхгүй юу. Улсын Их Хурал батлаад байгаа юм.

Энэ дотроо ачаалалтай байна уу, ачаалалгүй байна уу тэр цалингийнхаа нэмэгдлийг Ерөнхий зөвлөл өөрөө шийдээд явж байвал яасан юм бэ гэдэг ийм уян хатан тогтолцоо л оруулж ирж байгаа юм. Ерөөсөө.

Тэгээд энэ ажлын хэсгийн саналаар хасахаар ороод ирчихсэн байна л даа.

Тэгээд энэ бас нэг зарчмын ийм нэг санал байгаа юм. Ер нь шүүх эрх мэдлээ эдийн засаг, нийгмийн баталгааг төр хариуцна, хараат бус байна гээд

байгаа шүү дээ. Тэгэхийн тулд Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана гээд Үндсэн хуульд байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид ер нь энэ шүүх эрх мэдлээ үүнд нэг бие даалгавал бас нэг бие даалгасан шиг, тэр хараат бус байдлыг нь бас нэг хангавал хангасан шиг байдлаар явбал яасан юм бэ?

Шүүхийн ерөнхий зөвлөл тэр пин пангүй дураараа цалинг нь нэмээд байж чадахгүй.

Яагаад гэхээр Улсын Их Хурал.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүн нэмж хэлэх юм уу? Ц.Сэргэлэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Сэргэлэн: Би үг хэлье ч гэж бодоогүй л сууж байлаа.

Зүгээр сая Б.Энхбаяр гишүүний энэ саналтай холбогдож хийсэн тайлбарыг хараад байхад бас нэлээд ач холбогдолтой асуудлууд ярьж байна.

Ялангуяа тэр цалинтай холбоотой асуудал. Тим уян хатан байх хэрэгтэй. Би тэрийг дэмжмээр байна. Тэгээд энд хасах гээд ороод ирсэн гэж байна.

Эхний асуудал дээр би жинхэнэ ажлын хэсэг дээр байж байгаа шүүхийнхний саналыг бас сонсмоор санагдчихлаа.

Яагаад гэхээр сая Б.Энхбаяр гишүүний тайлбар дунд орон гарсан буюу орон тоо нь гарсан тэр шүүгчийн орон тоон дээр сонгон шалгаруулалт явуулахгүй ингээд бариад байгаа нь тэр ажлаа өгсөн шүүгчтэй холбоотой юм шиг

би тэгж ойлголоо. Буруу ойлгосон ч байж магадгүй.

Тэгээд ажлаа өгөөд яваад өгсөн хүн эргээд нөлөөлөөд байдаг юм уу, үгүй юм уу. Энэ ямар зарчим байдаг юм бол? Тийм.

Тэгэхээр энэ асуудал дээр би энэ ажлын хэсэгт ажиллаж байгаа жинхэнэ энэ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тодруулж болдог асуучихмаар байна.

Дэгээрээ асуулт байна уу, үгүй юу? Байвал асуучихъя. Болж байна. Тэгвэл би.

Д.Цогтбаатар: Яг асуулт асуух процесс явж байгаа.

Ц.Сэргэлэн: Зөв зөв. Би зүгээр санал хураалттай холбоотой үг хэлж байна гэж ойлгоод.

Д.Цогтбаатар: Үгүй.

Ц.Сэргэлэн: За за. Тэгэхээр би нэгдүгээр асуудал дээр Б.Энхбаяр гишүүний гаргасан зарчмын санал дээр одоо ажлын хэсэгт ажиллаж байгаа мэргэжлийн шүүхийн байгууллагын төлөөллөөс ямар бодол саналтай байдаг юм. Асууя л гэж бодсон юм.

Яагаад гэвэл ажлаа өгөөд явчихсан хүн эргээд нөлөөлөөд байгаа нь ямар учиртай юм?

Тэгээд дахин хүнийг томилох тэр хугацаанд хүртэл орон гараад байгаа нь үнэн юм уу? Ер нь ийм зарчим байдаг юм уу?

Ер нь та бүхэн ямар саналтай байгаа юм? Яагаад ажлын хэсгээс үүнийг хасъя гээд ороод ирсэн юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон. Л.Энхбилэг даргад өгье.

Л.Энхбилэг: Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Ер нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Сахилгын хорооны гишүүн 4, 6 жилээр сонгогдож явсан тохиолдолд сул орон тоо үүсээд, тэнд ачаалал үүсэж байгаа нь үнэн.

Ганц хяналтын шатан дээр ч биш. Давах, анхан шатан дээр.

Өөрөөр хэлбэл давах дээр 2 шүүгч. Нэг нь Шүүхийн ерөнхий зөвлөл байна. Нэг нь Сахилгын хорооны гишүүнд сонгогдоод явж байгаа тохиолдолд тэнд 2 шүүгчийн сул орон тоо үлдэж, одоо ажиллаж байгаа шүүгч нарт ачаалал үүсэж байгаа нь үнэн.

Энэ асуудлыг зохицуулахаар энэ хуульд орж ирсэн байснаа хасагдаад “Шүүхийн нээлттэй, ил тод байдал” гээд Д.Цогтбаатар гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг дээр энэ томъёологдоод орчихсон байгаа. 32.2.4, 32.2.5 гээд.

2.4 дээрээ болохоор давж заалдах болон анхан шатны шүүхийн шүүгчийн бүрэн эрх энэ хуулийн 39.1-д заасны дагуу түдгэлзсэнд тооцогдсон бол тухайн шүүхэд мөн тооны орон тоо нэмэх бөгөөд нэмсэн тухайн өдрөөс хойш 14 хоногийн дотор гээд.

2.5 дээр яг хяналтын шатны шүүхийн энэ асуудлыг зохицуулчихсан.

43.6-аар болохоор Ерөнхий зөвлөл болон Сахилгын хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж, дараагийн гишүүн сонгогдсоноор бүрэн эрхийн хугацаа

дууссанаар урьд ажиллаж байсан шүүхэд эргэн ажиллах баталгаагаар хангагдана гээд оруулчихсан юм.

Яг одоо байгаа хууль дээрээ энэ байгаагүй учраас бид яагаагүй. Одоо энэ хуулиар ингээд орчих юм бол үүнийг хэрэгжүүлэх боломжтой.

Дараагийн төсөл дээр явагдаж байгаа шүү. Б.Энхбаяр сайд аа. Тийм.

Д.Цогтбаатар: Л.Энхбилэг дарга яг энэ дээр хариулаадаа даа. Яагаад гэвэл Б.Энхбаяр сайдын яриад байгаа логиктой зөв юм яриад байна шүү дээ. Бас.

Л.Энхбилэг: Дээд шүүх дээр нэмэгдэхгүй.

Угаасаа орон тоо нь гараад л, дараагийн шүүгч нь сонгогдоод л явчихна. Солигдоод.

Анхан болон давах дээр бол нэмэх юм. Үүнийгээ бид орон тооны дээд хязгаарыг Ерөнхий зөвлөл өөрөө тогтоодог гэдэг агуулгаар нь бид тэндээ зохицуулж болно гэсэн агуулгаар хэлж байгаа юм.

А.Насандэлгэр гишүүн энэ дээр нэмж хариулна.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон нэмээд хариулъя. 3 дугаар микрофон.

А.Насандэлгэр: Тийм. Сая Л.Энхбилэг дарга хариуллаа.

Тэгэхдээ ажлын хэсэг дээр яригдсан зүйл бол энэ бол Дээд шүүхийн санал байсан.

Тэгээд Дээд шүүхийн санал ажлын хэсэг дээр хэлэлцэгдээд. Саяын хэлдэг нөгөө ажлын хэсэг дээр хэлэлцэгдээд явж байгаа томъёолол нь өөрчлөгдөөд явж байгаа учраас тэр ажлын хэсэг дээр нь шийдээд явъя гэдгээр л ажлын хэсэг дээр хасагдсан юм.

Түүнээс биш дэмжээгүй асуудал тэнд яригдаагүй.

Сул орон тоо нөхөгдөх тухай асуудал Шүүхийн тухай хууль дээр нэг л орох учраас нөгөө ажлын хэсэг дээр хэлэлцэгдээд явах нь зөв өө гэдэг агуулгаар энэ ажлын хэсгээс хасагдсан байгаа.

Д.Цогтбаатар: Нэгэнт ажлын хэсэг энэ саналаа оруулаад ирчихсэн байгаа болохоор ажлын хэсгийн томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн томъёоллоор санал оруулсан байгаа.

Үүгээр санал хураалт явуулъя.
/алх цохив/

40.0 хувиар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Ш.Адъяаа гишүүнээр тасаллаа. Н.Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Та нар минь хоорондоо ярьж байгаад зөрчилгүй л юм оруулж ирвэл сайн байна л даа.

Би та нарын ярьж байгааг сонсохоор зөрчилтэй юм харагдаад л байна.

Би их сургуулийн багш байхад илүү цаг хийхдээ баярладаг л байсан юм. Мөнгөө авдаг байхгүй юу. Илүү цагийн мөнгө. Их сургуулийн багш 850 төгрөгийн цалинтай. Илүү цаг гээд 1200 төгрөгийн цалин авна.

Би одоо энэ зах зээлийн нөхцөлд яаж зохицуулах юм мэдэхгүй байна л даа.

Нөгөө талаасаа орон тоог нэмэхгүй байх сонирхол чинь би тэр цагийг нь заагаад мөнгийг нь авчихъя гэдэг сонирхол байдаг юм л даа. Б.Энхбаяр сайд.

Тэгээд та нар энэ зах зээлийн нөхцөлд түүнийгээ яаж зохицуулдаг юм.

Одоо та нар ингээд ерөөсөө мөнгө төгрөгт нь халдаад яадаг юм. Шүүхийн ерөнхий зөвлөлд өгчихье гэхээр би жишээ нь тэр Л.Энхбилэгийн оронд байсан бол тэгж л бодно.

Үгүй ээ, тэгээд та нар зохицуулаад ажиллачих л даа. Тэгээд л мөнгөө ав л даа л гэх байлгүй дээ. Ийм зөрчилтэй хоёр юм яваад байх юм. Та нар үүнийгээ ажлын хэсэг дээрээ сайхан ярьж байгаад зөв зохицуулалт хийж болдоггүй юм уу? Орон тоо зарла гэж шаардах юм. Тэгсэн мөртөө дахиад тэндээ мөнгөө та нар зохицуул гэж шаардах юм.

Би наад хоёрын чинь зөрчилтэй л зүйл байна гэж зүгээр харж байна. Би асууж байгаа юм байхгүй шүү. Зүгээр зохицолдуулаад зөв хийгээрэй.

Ер нь Б.Энхбаяр сайд нэг хэсэг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар гэдэг хүний хармаанд байсан юмыг бид бас ярьж байгаад шүүхийн төсвийг чинь юун дээр авсан шүү дээ. Байнгын хороон дээр.

Тэр биеэ даасан маягийн болгоё гэдгийг чинь бид уг нь дэмжээд, механизмаар нь хийх гэж оролдоод л тэгээд бас чадахгүй л байна.

Саяынхыг та нар жаахан ярьж байгаад зөв шийдэхгүй бол би одоо ингээд шууд зөрчилтэй асуудал дээр гараа өргөнө, өргөхгүй гэхээр жаахан хэцүү байна шүү.

Д.Цогтбаатар: Ш.Адъяшаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адъяшаа: 2 дугаар зүйлтэй холбогдуулаад шүүгч нарыг шилжүүлэх, хамт ажиллахтай холбоотой энэ асуудлыг нэгдсэн ойлголттой болмоор байна.

Одоо энд нэгдмэл сонирхол гээд нэг юм яваад байгаа шүү дээ. Одоо манай Б.Энхбаяр сайд байнга ярьдаг.

Энэ нэгдмэл сонирхол гэдэг юмаа эхэлж шийдье. Одоо тийм хамааралтай, ийм хамааралтай гээд л. Тэгсээр байгаад л сүүлд нь энэ чинь энэ нийгмээ бүтэн бид талцуулаад бантан болгочоод байгаа шүү дээ.

Тэгээд дээр нь Хууль зүйн байнгын хороо шүүхийн төсөв, бусад хуулийн байгууллагын төсвийг баталдаг юмаа болох хэрэгтэй.

Монгол Улс чинь нэг л журмаар төсөвтэй байгаа шүү дээ. Төсвийн асуудлыг зөвхөн төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна гэж байхад өнөөдөр Шүүхийн тухай хуулиар ямар асуудал авч ирсэн юм. Өнөөдөр шүүх эрх мэдлийг хууль тогтоох эрх мэдлийн хараанд авч ирсэн шүү дээ. Шүүхийн тухай хуулиар. Би зөндөө ярьж байсан.

Тэгээд өнөөдөр шүүхийн төсөв энэ төрийг Хууль зүйн байнгын хороонд шийддэг. Энэ чинь Улсын Их Хурал өөртөө давуу байдал олгож байгаа шүү дээ. Тэгээд үүнийг нь өнөөдөр бид яахаар ярьж байдаг юм. Улсын төсвийг хаана баталдаг юм. Сангийн яам баталдаг юм шүү дээ.

Тэгээд өнөөдөр шүүхийн болон бусад хуулийн байгууллагын төсвийг өнөөдөр Хууль зүйн байнгын хороонд баталдаг энэ чинь угаасаа хууль зөрчигдөж байна. Энэ асуудлаа Засгийн газар нь татаж ав. Ийм байж болохгүй шүү дээ.

Өнөөдөр шүүхийг бие даасан байлгая, шүүхийг хараат биш байлгая гэж ярьсаар байгаад нэг гараараа тэгж ярьчихаад, нөгөө гараараа өнөөдөр төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурал өнөөдөр шүүх эрх мэдлийг хараандаа авч ирчхээд тэгээд шүүхийн төсвийг, хуулийн байгууллагын төсвийг яахаараа Хууль зүйн байнгын хороонд баталдаг юм бэ? Энэ алдаагаа яагаад бид дахин давтан сүүлд нь төгсгөл рүү нь бүр үүнийг баталгаажуулах гэж оруулж ирдэг юм.

Хууль зүйн байнгын хороонд чинь төсөв баталдаг байгууллага юм уу? Хуулийн хэрэгжилт нь Монгол Улсын хэмжээнд хяналт тавьдаг байгууллага шүү дээ.

Тэгвэл тэр Төсвийн байнгын хороогоор нь батлуулъя. Сангийн яамаар нь батлуулъя. Ийм асуудлыг өнөөдөр орж ирчхээд энэ төгсгөл рүү нь ингээд нэг муур хулгана болж байгаа ч юм шиг, өнөөдөр сайн сайхан юм ярьж байгаа ч юм шиг ийм зарчим байж болохгүй. Энэ дээр би бүр хатуу эсрэг байр суурьтай байна.

Д.Цогтбаатар: Асуулт биш байр суурь болоод явчихлаа. Тийм ээ.

Тийм. Яах вэ, Ш.Адъяаа гишүүн ээ, үүнийг харин оруулж ирж байгаа чинь уг нь аминдаа харин эд нарын хараат бус байдлыг бэхжүүлж өгөх гэж л оруулж ирж байгаа шүү дээ.

Сая хүртэл Б.Энхбаяр сайдын гаргаж байгаа зарчмын зөрүүтэй санал чинь түрүүний зүйлийг хэлэлцэж байхад ярьж байсан зүйл чинь Сангийн сайдын үүдэнд шүүгчдийг байлгамааргүй байна л гэдэг асуудлыг яриад. Харин илүү хараат бус байлгая л гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр тэгж ойлгож оруулж ирж байгаа шүү. Д.Ганбат гишүүнд микрофон өгье.

Д.Ганбат: Ер нь энэ Засгийн газар, энэ Улсын Их Хурал цөөхөн зөв юм хийж байгаагийн нэг нь энэ. Тийм.

Шүүхийн хуулийг, шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд энэ хууль хэрэгтэй. Тэр тусмаа дараагийн 126 хүн орж ирнэ шүү дээ. Тэр хүмүүс чинь учраа олтол бас нэг, хоёр жил болно.

Тэгэхээр бид энэ чуулганаараа энэ хуулийг ярилцаад батлаад ингээд явчих нь зүйтэй юм. Тэгээд саяын тэр хэлэлцэж байгаа асуудлаар түрүүний хэлдэг хоёр гишүүнээс арай өөр байр суурьтай байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл 5 гишүүн нь шүүгч гишүүн байгаа байх. 10 гишүүнээс.

Тэгээд шүүгчид нь шүүхээ сайн мэднэ. Тэр төсөв хөрөнгө, орон тоо, энэ тэр жоохон юмыг нааш цааш нь. Тэр

юмыг Улсын Их Хурал руу бариад л байнга гүйгээд байх дэмий.

Тэнд чинь ганцхан жилийн дотор, хоёрхон жилийн дотор энэ Хан-Уул дүүрэг гэхэд хэчнээн олон хүнтэй болж байна. Тэнд чинь шүүхийн үйлчилгээ хэрэгтэй байна.

Энэ байшин барилга гэхэд ямар байгаа билээ. Үнэхээр ичмээр байдаг шүү дээ. Бүгдээрээ л шүүхийг янз бүрээр хэлдэг. Тэгсэн мөртөө амаараа л яриад байхаас биш гар хуруугаа ерөөсөө хөдөлгөдөггүй. 8 жил.

Би л байж байхдаа, Ардчилсан нам байх үедээ нэг цалин цавуу нэмсэн. Түүнээс хойш энэ Их Хурал, энэ Засгийн газар байхад тэр 10, 20 жилээр нь барилга байшингаа сайжруулах ийм тогтоолыг саяхан баталсан. Ийм ийм зүйлүүд байгаа.

Тэгэхээр Хууль зүйн байнгын хороон дарга аа, өөрийнхөө нөхдүүдийг хурдан түргэн дуудаад, энд суулгаад, ингээд энэ тогтоол хууль юмаа сайн хэлэлцээд батлаад явчих нь зүйтэй.

Энэ чинь дараа нь ингээд бас энэ Их Хурлын, энэ Хууль зүйн байнгын хорооны хийсэн ажил болоод үлдэнэ гэж ойлгож байна.

Харин ч долоо хоног завсарлаад хойшлуулаад хоёрын хооронд өөрсдөө сонгогдох гэж явсаар байгаад ингэж таарсан байна шүү.

Бид бүхэн байж байгаа хугацаандаа анхны хэлэлцүүлэг шүү дээ. Энэ чинь.

Манай Г.Амартүвшин гишүүн бид нэлээн сайн ажиллаж байгаа. Тэгээд

бэлэн болгоод өгсөн юмыг мэдээж хэрэг бүгдээрээ хуульч гишүүд байж байна.

Тэгээд Б.Энхбаяр сайд жоохон нэмж тайлбарлаад энэ юмыг одоо тэгээд тэр зөв зүйтэй голдиролд нь оруулсан нь зөв байх гэсэн ийм бодолтой байна.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүн таны саналтай санал нэг байна.

Манай Байнгын хороо харин завсаргүй бид оролцоно шүү. Би гишүүддээ энэ дээр талархал илэрхийлмээр байна.

Түрүүн ганц удаа л ёстой бусад Байнгын хорооноос бид нарын нэг онцлог бол. Түрүүн ганц удаа л үнэхээр жинхэнээсээ ирц бүрдээгүй.

Түүнээс бусад үед манай гишүүд бүгд ирцээ бүрдүүлээд, энэ ажлыг харин явуулж байгаа шүү.

Өнөөдөр ч гэсэн одоо энэ асуудлыг оруулж ирэхэд асуудал нь маш тулчихсан. Өнөө өглөө л бүр яг ажлын хэсэг хуралдаж байгаад л энэ материалуудаа бэлдэж орж ирж байгаа юм.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “тухайн шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан бол” гэснийг “тухайн шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан шүүгчийг албан ажлын зайлшгүй шаардлагаар” гэж өөрчлөх.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт явуулъя. /алх цохив/

70.0 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Б.Энхбаяр гишүүнээр тасаллаа. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Би түрүүн 3 дугаар зүйл дээр үг хэлсэн юм. Одоо чинь санал хураалтын 3 дахь заалтыг хураах гэж байгаа шүү дээ.

Энэ нөгөө саяын яриад байгаа Улсын Их Хурал хаашдаа Засгийн газрын өргөн барьснаар шүүгчийнхээ орон тоо, цалингийн санг улсын төсвөөрөө баталчхаж байгаа юм.

Гол нь заавал тусдаа тогтоолоор цалинг нь батлаад, тэгээд Хууль зүйн сайд нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргатайгаа жоохон таарамж муутай бол шүүгчдийн цалинг нь оруулж ирэхгүй арван хэдэн жил болчихсон.

Тэгээд одоо мөрдөгчдөөсөө бага цалинтай болчихсон. Улс төрчид нь болохоор зарим олон түмний хэл амнаас айгаад шүүгчийн цалин, асуудлыг ерөөсөө ярьдаггүй.

Тэгээд үүнийг нь оруулж ирэх тийм хүн байхгүй болчихсон.

Тэгээд одоо бид үүний цаана дараа нь мөрдөгчдийн цалинтай ярих гээд байгаа шүү дээ.

Мөрдөгчдийн цалин Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчдээс өндөр болчихсон. Энэ болохгүй шүү дээ.

Би хэн ажиллаж байгаад нь яриагүй байна. Зарчмын хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүх эрх

мэдэл хараат бус, бие даасан байх ёстой. Энэ эдийн засаг, нийгмийн баталгааг нь хангах ёстой.

Тийм учраас энэ асуудлыг нь ер нь нэгэнт Үндсэн хуульд заачихсан тэр Шүүхийн ерөнхий зөвлөл нь Улсын Их Хурлаас батлагдсан төсөвтөө багтаагаад тэр цалингийнхаа нэмэгдлийг өөрсдөө шийдээд явдаг байвал яасан юм бэ гэдэг ийм зарчмын саналыг л гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн өөрөө гаргасан юм. Үүнийг. Засгийн газрын хуралдаан дээр. Тийм. Тэгээд энэ саналаар орж ирсэн юм.

Тийм учраас 3 дахь саналыг дэмжихгүй байж, Засгийн газрын өргөн мэдүүлсэн төслөөр нь үлдээж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Б.Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Нэг хэсэг шүүгч нарын цалин нэлээн өндөр байсан. Үнэн.

Тэгээд бусад байгууллагууд нь нэлээн барьцдаг. Ялангуяа Ц.Нямдорж сайд өөрөө сайд байхдаа шүүгч нарын цалинг яахаараа ийм өндөр болгодог юм гэж маш их шүүмжилдэг.

Тэгээд л янз янзын юм яриад байхаар нь би аргаа бараад ерөөсөө энэ Ц.Нямдорж гуайн энэ шүүх рүү дайрдаг юмыг болиулахын тулд ямар арга хэрэглэсэн юм бэ гэхээр прокуроруудын цалинг нэмэгдүүлэх ийм саналыг 2016 оны намрын чуулган дээр гаргаад, тэгээд 2017 оны төсвөөр шийдэж байсан байхгүй юу даа.

Тэгээд прокуроруудын цалинг нэмэгдүүлчхэнгүүт тэрнээс хойш нөгөө Ц.Нямдорж гуай шүүх рүү цалин өндөр байна гэж дайрахаа больсон юм.

Тэгэхээр яах вэ, тухайн үед энэ нь бас зөв арга зам байсан л даа. Бусдаар юу байдаг юм шүүгч нарын цалинг буулгалтай биш. Ийм л байсан.

Тэгэхээр өнөөдрийн оруулж ирж байгаа энэ заалт Засгийн газраас дэмжээд орж ирж байна гэдэг чинь бас их зөв байна шүү.

Тийм учраас яг энэ дээр янз янзын өөр санал гаргахгүйгээр энэ Засгийн газрын оруулж ирсэн хувилбараар нь дэмжээд явчих юм бол шүүх бас тодорхой хэмжээгээр.

Мэдээж бид төсвийг нь ерөнхий баталж өгнө. Баталж өгөхдөө бас дотроо өөрсдөө зохицуулалтаа хийх тэр боломжийг нь нээж өгнө гэдэг бол энэ байгууллага өөрөө зардлаа зөв зарцуулах. Заавал одоо нэг тийм ийм юманд зарцуулна гээд л заачихаар чинь тэгээд ерөөсөө цалингийнхаа асуудлыг шийдвэрлэж болохгүй ийм нөхцөл байдал руу ороод байгаа.

Тийм учраас дотооддоо энэ асуудлаа шийдвэрлээд явах нь.

Ерөнхийдөө тэгээд ер нь шүүгч нарын цалинг тэд байна гээд улс төржиж зааж өгнө гэдэг бол ерөөсөө буруу л гэж үзэж байна. Тэгээд энэ зөв хувилбар шүү.

Тэгээд Засгийн газрын оруулж ирсэн хувилбараар нь явуулсан нь дээр.

Д.Цогтбаатар: Тийм тийм. Хурдан хурдан явъя.

Угаасаа сая танд тайлбарлачихсан. Манайхан очоод тайлбарлачихсан байгаа. Тийм ээ.

Б.Энхбаяр гишүүн ээ, микрофондоо ярих нь зөв байх. Яагаад гэвэл наадах чинь бүртгэгдээд үлдэг.

Зүгээр миний ойлгож байгаагаар та дараагийн саналыг л яриад байх юм.

Одоо бид 3 дугаар санал дээр. Тэгвэл ингээд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тэгээд ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. Энд хоёр санал байгаа.

Би ахиад уншаад танилцуулчихъя.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “Улсын дээд шүүхтэй зөвшилцөж” гэснийг, 2 дахь заалтыг тус тус хасах.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт явуулъя. /алх цохив/

Тэгвэл ингэе. Хоёр хуваагаад. Яагаад гэвэл таны тэр хасах гэж дэмжиж байгааг нь яагаад.

Б.Энхбаяр гишүүнд микрофон өгье.

Б.Энхбаяр: Энэ саналын томьёолол маань хуулийн төслийн хоёр өөр зүйл, заалтад байгаа хоёр өөр зарчмын зөрүүтэй асуудлаар нэг саналын томьёолол бичсэнээс болоод уначихлаа.

Саяын 3 дахь санал хураалт буюу төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “Улсын дээд шүүхтэй зөвшилцөж” гэснийг хасах гэдгийг тусад нь санал хурааж өгөөч ээ.

Харин төслийн 2 дахь заалтыг хасах гэдгийг мөн тусад нь санал хурааж өгөөч ээ.

Тэгэхгүй болохоор жишээлбэл 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “Улсын дээд шүүхтэй зөвшилцөж” гэснийг хасахыг би дэмжээд байгаа юм.

Харин төслийн 2 дахь заалтыг хасах гэдгийг нь болохоор дэмжихгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр хоёр өөр зарчмын байр суурьтай асуудлаар нэг саналын томъёолол болгоод санал хураах гэхээр санал өгч чадахгүй. Тэгээд саяын санал хураалт уначхаж байгаа юм.

Тийм учраас би хуралдаан даргалагчаас хүсэж байгаа нь 3 дахь саналын томъёололд байгаа хоёр асуудлыг хоёр тусад нь санал болгож санал хурааж өгөөч ээ гэсэн хүсэлттэй байна.

Д.Цогтбаатар: Та санал хүчингүй болгооч гэдэг горимын санал гаргах хэрэгтэй байна. Б.Энхбаяр гишүүний микрофоныг.

Б.Энхбаяр: Тийм учраас саяын хэлсэн үндэслэлээр саяын санал хураалтыг хүчингүйд тооцож, санал хураалтыг хоёр хувааж тус тусад нь явуулж өгөөч ээ гэсэн горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Горимын саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор саналыг.

Б.Энхбаяр сайдын гаргасан саналтай холбогдуулаад тэгэхээр томъёоллыг шинэчлээд уншиж танилцуулъя.

Энэ дээр харин хоёр тусдаа санал хураалгүй шууд нэг хэсгийг нь хасаад явчихлаар нөгөөдөх нь төслөөрөө үлдээд таны яг хэлж байгаагаар энэ явчхаж болж байгаа юм.

Тэгэхээр төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “Улсын дээд шүүхтэй зөвшилцөж” гэснийг хасах гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Б.Энхбаяр гишүүнд микрофон өгье.

Б.Энхбаяр: Үүнийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр нь дэмжиж өгөөч ээ буюу энэ санал хураалтыг дэмжихгүй байж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Яагаад гэхээр Засгийн газрын өргөн барьсан төсөл нь болохоор ийм өгүүлбэр байгаа юм.

Улсын дээд шүүхээс бусад шүүхийн шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно гэдэг ийм заалт байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ юуг хэлж байна вэ гэхээр одоо жишээлбэл, Ховд аймгийн эрүүгийн шүүх хэдэн орон тоотой буюу хэдэн шүүгч ажиллах юм. Багануур дүүргийн иргэний шүүх хэдэн иргэний шүүгчтэй байх юм бэ гэдгийг Улсын Их Хурал тогтоох юм. Улсын Их Хурал.

Яагаад гэхээр шүүхийг одоо хуулиар байгуулна гэж байгаа.

Одоо энэ ажлын хэсгийн саналаар болохоор Улсын Их Хурал зөвхөн орон тооны дээд хязгаарыг тогтооно гээд тэгчихээр одоо энэ Шүүхийн ерөнхий зөвлөл ингэж зальдах гэж байна.

Монгол Улс 600 шүүгчтэй байна. Анхан шатны шүүгчид нь 250 байна гээд Ерөнхий дээд хязгаар батлуулах гэж байна. Зөвхөн Улсын Их Хурлаар.

Тэгээд Ховдод 10 шүүгчтэй байх уу, 1 шүүгчтэй байх уу, Багануур 10 шүүгчтэй байх уу, 1 шүүгчтэй байх уу гэдгийг Ерөнхий зөвлөл дураараа мэдэх гэж байна.

Энэ бол ёстой аюултай. Ерөнхий зөвлөл өөрөө хонгил болно. Дургүй хүрсэн шүүгчийн орон тоог нь хасаж байгаад хөдөө цөлчихнө гэсэн үг. Ц.Элбэгдорж чинь ингэж шүүхийг гартаа оруулсан этгээд байхгүй юу.

Таалагдахгүй, үгэнд орохгүй байсан шүүгчдийг хөдөө явуулдаг, томилдог. Дүлий шүүгч гэж хэлдэг. Тэгж байгаад хонгил болгож атгадаа оруулж байсан юм.

Тийм учраас энэ өгүүлбэрийн цаана Шүүхийн ерөнхий зөвлөлийг бид бас хадны мангаа болгож болохгүй. Наадуул чинь одоо шүүгчдээ базах гэж байна. Үгэндээ орохгүй байгаа шүүгчийнх нь орон тоог нь хасаад хаячихна гэсэн үг.

Чингэлтэй дүүргийн шүүхийн иргэний шүүх 10 орон тоотой байлаа гэнгүүт таалагдахгүй байгаагаа 9 болгоод хаячихна гэсэн үг. 8 болгоно гэсэн үг. 7

болгоно гэсэн үг байхгүй юу. Энэ эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөлд өгч болохгүй.

Тийм учраас энэ хил хязгаараас давсан санал орж ирж байна гэж үзэж үүнийг би унагааж өгөөч ээ. Засгийн газрынхаа төслөөр нь байлгаач ээ гэсэн ийм саналтай байна.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон.

Н.Баасанжав: Шүүхийн ерөнхий зөвлөл орон тооны дээд хязгаарыг Улсын Их Хурлаар тогтоолгоё гэдэг шүүгчдийн орон тоотой холбоотой саналыг санаачилж оруулсан байгаа.

Тэгэхээр амьдрал дээр бол ажлын ачааллаас шалтгаалаад шүүхүүд маань өөр өөр байдалтай ажиллаж байна. Нийслэл буюу төвлөрсөн газрууддаа ачаалал маш их байгаа.

Орон нутагт ачаалал зарим газар хэвийн, зарим газар ачаалал бага байна.

Ачаалал их байгаа газруудын маань энэ өөрчлөлт нь их богинохон хугацаанд өөрчлөгдөж байна. Тухайлбал, 2016 онд Хан-Уул дүүрэгт 11 шүүгчийн орон тоотой байхаар баталсан буюу үүнээс хойш 4 жилийн дотор 19-өөс 21 шүүгчийн ачаалал тэнд нэмэгдсэн.

Энэ суурьшлын бүс нэмэгдэж байгаатай холбоотой шүүхийн ачааллууд өөрчлөлт ороод байгаа учраас энэ болгон дээр Улсын Их Хурлаас баталдаг тогтоолд өөрчлөлт оруулах тухай саналыг бид тухайн үед нь шийдвэрлүүлэх ийм асуудлууд амьдрал дээр гараад байгаа юм.

Тийм учраас бид Улсын Их Хурлын тогтоол буюу 2016 оны 42 дугаар

тогтоолоор шүүх болгон дээр заасан энэ орон тоог зөвхөн анхан буюу давж заалдах шатны шүүх дээр дээд хязгаарыг нь батлаад, ачаалал ихтэй байгаа шүүхүүдийг ачааллыг нь тэнцвэржүүлэх үүднээс маневр хийх ажил нь цаг хугацааны хувьд түргэн байх энэ асуудлынх нь үүднээс л бид энэ орон тооны дээд хязгаарыг тогтоож өгөөч ээ гэдэг ийм саналыг уламжилсан байгаа.

Б.Энхбаярын гишүүний ярьж байгаа энэ өнцгүүд бол бас байхыг үгүйсгэхгүй.

Гэхдээ Шүүхийн ерөнхий зөвлөл ямар нэгэн орон тоо хасах эрх хэмжээ байхгүй. Зөвхөн зохицуулалт хийх агуулгынх нь үүднээс л ийм төслийг оруулж ирсэн байгаа юм.

Тэгэхээр энэ төсөл нь байх юм бол уг нь Шүүхийн ерөнхий зөвлөлд уг нь хэрэгтэй л юм байгаа юм.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье.

Л.Энхбилэг: Хууль зүйн сайдын маань санаа зовниж байгаа, тэгж байгаа нь бас харах өнцөг байгаа байх л даа.

Гэхдээ Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно гэдэг нь яагаад эргээд шүүгчийн хараат бус байдалд халдахгүй вэ гэдэг өнцгийг хөндөх юм бол Шүүхийн ерөнхий зөвлөл захиргааны байгууллага. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд оролцдоггүй.

Тэгэхээр аливаа нэг шүүгчийг аль нэг газар шилжүүлж, орон тоог нь хасах байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бас тийм саад болох юм гарахгүй.

Хоёрдугаарт, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааныхаа статистикийг харж байгаад зохист ачааллын шалгуур үзүүлэлтийг бид гаргасан.

Зохист ачааллын шалгуур үзүүлэлтийг гаргахаар иргэний шүүгчийн хувьд жилд 209 хэрэг шийдэх юм байна. Эрүүгийн шүүгчийн хувьд жилд 105 хэрэг гээд анхан шатны.

Тэгэхээр тэр тоондоо тохируулаад, тэр тоо маань өсөөд, буураад байх тохиолдолд бид илүү маневр хийх, шүүгчээ шилжүүлэх, орон тоогоо зарлах тэр боломж нь байх юм бол уян хатан, богинохон хугацаанд орон тоогоо шилжүүлээд иргэдийн шүүхээр үйлчлүүлэх, иргэдийн шүүхэд хандах тэр эрхийг илүү хангах баталгаатай болно.

Тэгээд энэ утгаараа хараат бус байдал нь тэр болгон Улсын Их Хурал руу ирж ингэж орон тоог шийдүүлэхгүй байснаар хараат бус байдлаа илүү хангаж ажиллаж, уян хатан ажиллах юм байна л гэж хараад байгаа юм.

Одоо ингээд цахимжуулалт нэвтэрнэ гэж байна. Цахимжуулалт нэвтрэхээр эргээд нөгөө зохист ачаалал арай өөр болоод, эсвэл гэр бүлийн шүүх, хялбар ажиллагааны шүүх бий болоход тийшээгээ нөгөө нэмэгдэхүүнүүдийн байр солигдох гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр тохиолдол болгонд нөгөө нийт орон тоогоо дахиж ирээд л гэр бүлийн шүүх дээр нь тэдэн шүүгчийг, хялбар ажиллагаа дээр тэдэн шүүгчийг гэдэг ийм юм гарах гээд байдаг.

Хэрвээ тэр нь анхан шатны нийт орон тооны хүрээнд байх юм бол бид

нэмэгдэхүүний байрыг нь илүү солих дээр үүнийг хийх боломжтой.

Тэгээд хоёр үндэслэл нь зохист ачаалал гэдэг шалгуур үзүүлэлтдээ баригдана.

Хоёрдугаарт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө оролцдог байгууллага биш учраас энэ дээр тэгж айхтар хараат бус байдалд нь халдахгүй, хөндөхгүй байх боломжтой юм болов уу гэж харж бид энэ томьёоллын оруулж ирсэн байгаа шүү.

Д.Цогтбаатар: Тайлбарыг сонслоо.

Тэгэхдээ түрүүчийн санал хураалт дээр энэ нэгэнт хасагдсан буюу үүний үр дүнд ямар үр дагавар гарч байна гэхээр Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсөл босож байгаа. Түүгээрээ дэмжигдээд явж байгаа учраас одоо энэ дээр санал хураах шаардлагагүй болчхож байна.

Тэгэхээр дараагийн асуудалдаа орьё.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

5.Төслийн 4 дүгээр зүйлийн “89 дүгээр зүйлийн” гэсний дараа “89.1 дэх хэсгийн “, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан” гэснийг,” гэж нэмэх.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт явуулъя. Асуулт асууж болно шүү дээ.

Б.Энхбаяр сайдад асуулт өгье.
Б.Энхбаяр сайдын микрофоныг.

Б.Энхбаяр: Энэ ямар заалт гэхээр шүүхэд хоёр албан тушаал захиргааны ажилтан байгаа юм.

Нэг нь, шүүхийн туслах, шүүгчийн туслах, нэг нь шүүх хуралдааны нарийн бичиг гэсэн хоёр ажил байдаг.

2021 онд бид Шүүхийн тухай хуулийг батлахдаа шүүгчийн туслах нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан буюу хуульчийн шалгалтад тэнцсэн хүн байна гээд хуульчилсан юм.

Ингээд үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой хоёр жилийн хугацаа өгсөн. Өөрөөр хэлбэл одоо шүүгчийн туслахаар ажиллаж байгаа бөгөөд хуульчийн гэрчилгээгүй хүмүүсийг шалгалтдаа тэнцэх хоёр жилийн хугацаа өгсөн юм.

Шүүх хуралдааны нарийн бичгийн тухайтад заавал хуульчийн шалгалтад тэнцсэн байхыг шаардахгүй. Эрх зүйч буюу 4 жилийн эрх зүйн бакалавр хүн бол шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хийгээд явж байгаа.

Одоо энэ санал хураалтаар яах гээд байна вэ гэхээр шүүгчийн туслахуудыг хуульчийн шалгалтад тэнцсэн байхыг шаардахгүй болгох гэж байна гэсэн үг.

Үүний шалтгаан нь одоо ажиллаж байгаа олон шүүгч нарын туслахууд нь хуульчийн шалгалтдаа тэнцэхгүй байгаад байна гэсэн үг.

Тэгэхээр бид тэр хүмүүс тэнцэхгүй байгаагийн төлөө шүүгчийн шийдвэрийг бичдэг өндөр шаардлага

тавьж байгаа энэ юмаа сулруулах ёстой юм уу.

Энэ шүүгчийн туслах гэдэг хүмүүс чинь шүүхийн шийдвэр бичээд байгаа хүмүүс байхгүй юу. Илүү хуульчийн гэрчилгээтэй, шалгалтдаа тэнцсэн байх ёстой ийм өндөр шаардлага зориуд тавьсан байхгүй юу.

Зүгээр 4 жил бакалавр төгсчхөөд шууд шүүхийн шийдвэр бичээд байж болохгүй шүү гэж хэлж байгаа байхгүй юу.

Тэгэнгүүт одоо байгаа юмандаа тааруулаад сулруулах гээд байгаа байхгүй юу.

Одоо байгаа тэр нэг Бат байна уу, Цэцэг байна уу, шүүгчийн туслах нь энэ хуульд заасан шаардлага хангахгүй байна гээд.

Хэрэв одоо энэ нь шүүхийн захиргаанд хүндрэл учруулаад байгаа бол тэр дагаж мөрдөх журмын хуулиараа энэ хуулиа дахиад нэг жилийн хугацаагаар дахиад нэг жилээр сунгая л даа. Тэгвэл. Тэр хүнийг дахиад нэг тэнцэх боломж олгоё.

Одоо энэ чинь 3 дахь жилдээ бид хугацаа олгоод явж байгаа юм. Шалгалтдаа тэнцэхгүй байгаа бид Батад 3 жилийн хугацаа өгөөд байна шүү дээ. Чи шалгалтдаа тэнцээд өгөөч ээ гээд.

Үгүй тэгээд тэнцэхгүй байгаа хүнийг яахаараа бид бүр хуулиар авч үзэж тэр шаардлагыг нь сулруулах ёстой юм бэ.

Тийм учраас энэ санал хураалтыг дэмжихгүй байгаа. Дэмжихгүй тохиолдолд дагаж мөрдөх журмын

хуулиараа дахиад нэг жилийн тэгвэл хугацааг нь сунгаж өгье л дөө.

Түүнээс биш шүүгчийн туслах хүн хуульчийн шалгалтад тэнцсэн байхыг шаардахгүй гэдэг бол энэ бол одоо аягүй том сулралт болох гээд байна.

Яагаад хуульчийн шалгалтыг бид авдаг юм бэ. Яагаад энэ эрх зүйч хүмүүсээс шаардлагыг нь өндөрсгөж байгаа юм бэ.

Бид шүүх хуралдааны нарийн бичиг дээр нь “окэй” гээд байгаа шүү дээ. Заавал ч хуульчийн шалгалтад тэнцсэн байхыг шаардахгүй байгаа.

Энэ чинь шүүгчийн туслах яриад байгаа байхгүй юу. Яг шүүхийн шийдвэр бичдэг хүмүүс байхгүй юу.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс тайлбар. Г.Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Баярлалаа. Б.Энхбаяр сайд аа. Энэ шүүх байгуулах тухай хуулийн ажлын хэсгийн гишүүд ер нь аль болохоор энэ орж ирсэн саналуудыг дэмжээд, энэ шүүхийн институцийг аль болохоор бид бүх талаас нь дэмжээд явъя гэсэн тийм үзэл баримтлалтай. Энэ ажлын хэсэг дээрээ ер нь хоёр, гурван удаа хуралдсан л даа.

Цалин хөлс байна. Орон тоо.

Бид нарын яг энэ заалт дээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ямар тайлбар бид нарт тавьж байгаа вэ гэхээр одоо энэ шүүхийн шүүгчдийн туслахуудын орон тоон дээр ерөөсөө шинээр хүн нь орж ирэхгүй байна.

Шалгуур нь хэт өндөр байна. Ачааллаа дийлэхээ больсон. Шүүх нь

хуралдаад шүүхийн шийдвэр нь гарахдаа маш удаж байна.

Энэ дээр нэгэнт л өмгөөлөгчийн эрх авсан залуучууд нь ерөөсөө өмгөөллийн бизнес рүүгээ ороод явж байна. Шүүгчийн туслах болох ямар ч сонирхолгүй болсон байна.

Тийм болохоор ажлын хэсгээс Шүүхийн ерөнхий зөвлөлд энэ орон тоог зохицуулах, ачааллыг зөв хуваарилах энэ зохицуулалтыг нь дэмжиж өгье гэсэн байдлаар бид энэ зарчмын зөрүүтэй саналыг нь дэмжсэн юм.

Энэ дээр манай ажлын хэсгийн гишүүн Ц.Сандаг-Очир яг амьдрал дээр тулгамдаж байгаа асуудлын талаар бас нэмж хариулна байх гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: 4 дүгээр зүйлийн 89-ийн энэ заалт дээр шүүгчийн туслах заавал хуульч, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хүн байх албагүй ээ л гэж байгаа юм.

Сая орон нутагт ажиллахад яг албан ёсоор дүүргүүдийн шүүх, шүүхийн захиргааны ажилтнуудтай уулзсан. Бүгд нэг дуугаар шүүгч нь ч тэр, захиргааны ажилтнууд нь ч энэ асуудлыг дэмжиж байна лээ.

Одоо энэ хуулийн төсөлд ингэж явж байгаа юм байна.

Тэгэхгүй бол ерөөсөө энэ шүүгчийн туслах хийх хүн чинь олдохгүй байгаа юм байна. Олдохгүй байгаа юм байна. Шүүгчийн туслах хүн бол эрх зүйч байхад болно.

Заавал тусгай шалгалт өгсөн, эрх авсан хуульч хүн байх албагүй юм гэдгийг захиргааны ажилтнууд ярьж байна лээ шүү.

Тийм учраас би энэ асуудлыг ажлын хэсэг дээр ярьсан. Ажлын хэсэг үүнийг дэмжээд явсан. Дэмжсэн.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон өгье. Л.Энхбилэг дарга.

Л.Энхбилэг: Б.Энхбаяр гишүүний ярьж байгаа тэр шүүгчийн туслах бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна гэдэг яг амьдрал дээр хэрэгжихгүй байгаа юм. Хүний нөөцтэйгөө ч холбоотой.

Хоёрдугаарт, шүүн таслах ажиллагаанд шүүгчийн туслах оролцохдоо ерөнхийдөө яг бодит байдал практикт тэр техник ажиллагаа л хийж байгаа. Яг тэр шүүхийн шийдвэрийг нь бичээд сууж байгаа цаг зав ч олдохгүй.

Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэрийн удиртгал хэсгийг л бэлдэж өгч байгаа юм. Ерөнхийдөө төсөл бэлдэж байна л гэсэн үг. Шүүгчид төсөл бэлдэж өгдөг. Удиртгал хэсгийг.

Түүнээс биш яг шүүхийн шийдвэрийг бичээд байгаа асуудал яг бодит амьдрал дээр байхгүй. Голчилж дандаа техник ажиллагаа хийж байгаа.

Хэргийн оролцогчтой байнга харьцаж байна, хэрэг үдэж байна, хүнээ дуудаж байна гэсэн иймэрхүү техник ажиллагаануудыг хийж байгаа юм.

Тэгэхээр энэ хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа зөвшөөрөлтэй байх гэсэн энэ шаардлагыг хангадаг туслахууд байхгүй.

Хангалаа гээд бодоход маргааш нь бараг ажлаа орхиод л өмгөөлөгч, прокурорын туслах, энд тэнд хуулийн зөвлөх.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Нэмэх үү? Л.Энхбилэг дарга. Л.Энхбилэг даргын микрофоныг. 4 дүгээр микрофон.

Л.Энхбилэг: Дээр нь цалинтай холбоотой, ачаалалтай холбоотой, цаг наргүй ажилтай холбоотойгоор орон тооны бид дутагдалд орж байгаа.

Ерөнхий зөвлөл байгуулагдахад нэг жилийн хугацаатай орон тоо, ингээд цикл байсан бол одоо бараг 3, 6 сарын хугацаатай ингэж хүний нөөцийн эргэлтэд ороод бид хүний нөөцийн хувьд дутагдалтай.

Ажиллаж байгаа албан хаагч маань ч тогтвор суурьшилтай ажиллах тэр нөхцөл бололцоогүй болчихоод байгаа юм.

Тэгээд үүнийг харгалзаж үзээд энэ хуулийг дэмжиж өгөөч, энэ заалтыг дэмжиж өгөөч ээ гэж гишүүдээс хүсэж байна.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр сайд аа, энэ дээр би нэг тайлбар хийчихье.

Би яг өөрөө биечилж шүүхүүд дээр явж, газар дээр танилцсан.

Тэгээд үнэхээр амьдралд хэрэгжихгүй. Одоо эд нар амьдралаас бодит үнэнээ л ярьж байна.

Бид хэрэгжихгүй хууль, амьдралаас тасарчхаад байгаа хууль батлаад өгчихөөр амьдрал дээрээ юу болж гарч ирээд байна гэхээр бид юмыг

сайжруулах гэсэн биш бодит яг хэрэгжилт дээрээ муудаж очоод байгаа байхгүй юу. Тусгал нь.

Тэгээд үүнийг яг газар дээрээсээ энэ шүүгчид өөрсдөө үүнийгээ бүр тусгайлан явсан газар болгонд тавьсан юм шүү.

Тийм учраас энэ саналыг дэмжиж өгөх нь зөв байх гэж бодож байна.

Тэгээд үүгээр би түрүүн уншиж танилцуулсан. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

50.0 хувиар энэ санал унаж байна.

Тэгвэл та горимын санал гаргачих. Б.Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: Би сая энэ саналыг дэмжиж өгсөн юм. Тэгсэн төхөөрөмж ажилласангүй.

Тийм учраас энэ саналыг хүчингүй болгох санал хураалт явуулж өгөөч ээ гэсэн горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. /алх цохив/

Түрүүн төслийг уншиж танилцуулсан байгаа. Тэгээд түрүүний томьёоллоор санал хураалтыг дахин явуулъя. /алх цохив/

58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 2 санал байгаа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13 дахь хэсэг нэмсүгэй:

“13.Энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ, энэ хуулийн 31.4, 31.5 дугаар зүйлд заасан баривчлах ажиллагаа, Арван долдугаар бүлэгт заасан хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийг нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар

ажиллагааны анхан шатны тойргийн шүүх хянан шийдвэрлэнэ.”

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт. /алх цохив/

Ц.Мөнхцэцэг гишүүн горимын санал гаргая. Ц.Мөнхцэцэг гишүүний микрофон.

Ц.Мөнхцэцэг: Саяын санал хураалт дээр миний төхөөрөмж гацсан учраас энэ санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү?

Д.Цогтбаатар: Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн саналаар санал хураалт явуулъя.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд түрүүн уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалт явуулъя.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. Нэг санал байна.

3.Төслийн 2 дугаар зүйлийн ““АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ” гэсний дараа “НЭГДҮГЭЭР ДЭД БҮТЭГ” гэж,” гэснийг хасах.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Нэг санал байна.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “шүүхийн” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж, “шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж,” “31.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж, 31.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж,” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт. /алх цохив/

58.3 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгийн саналгүй.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 2 саналтай байгаа.

5.Төслийн 5 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Шүүх шүүх байгуулах тухай хууль /Шинэчлэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал гаргасан “Ажлын хэсэг”. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/ /алх цохив/

Ажлын хэсгийн саналгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Ажлын хэсгийн бэлтгэсэн саналгүй.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал Байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна. /алх цохив/

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Шүүх байгуулах тухай хуулийг дагаж гарах Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой ажлын хэсгээс нэг санал хураалт хураагдах гээд байна. Энэ эхний санал хураалт нь.

Энэ санал хураалт нь 3 тусдаа зүйлийг нэг амьсгаагаар санал хураах гээд байна л даа.

Тэгэхээр энэ дотор нь дэмжиж байгаа санал байна, дэмжихгүй байгаа санал байгаа байхгүй юу.

Тэгэхээр түрүүнийх шиг нэг санал хураалтаар шийдэх боломжгүй байдалд, саналаа өгөх боломжгүй байдалд орчхоод байна.

Тийм учраас саналын томъёоллын нэгд байгаа 1 дүгээр зүйлтэй холбоотой 3 санал хураалтыг тус тусад нь санал хурааж өгөөч ээ гэсэн горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Тэгвэл яг энэ юугаар гурав хувааж санал хураалт явуулах нь байна шүү дээ.

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын “нэмэлт” гэснийг хасах гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Дараагийн томъёолол тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх” гэснийг хасах.

Б.Энхбаяр гишүүнд үг өгье. Микрофоныг нь өгье. Б.Энхбаяр гишүүний микрофоныг.

Б.Энхбаяр: Шүүх байгуулах хуулийг Засгийн газраас өргөн барихтай холбоотойгоор Шүүхийн ерөнхий зөвлөлөөс энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой эдийн засгийн тооцооллыг гаргасан байдаг.

Энэ чинь 200 гаруй тэрбум билүү? Аан. 340 тэрбум шаардлагатай гэдэг тооцоо гарсан юм. Яг энэ хуулийг хэрэгжүүлэхэд.

Үүний дийлэнх нь шинээр байр барихтай холбоотой асуудал байсан юм.

Тэгэхээр Засгийн газар дээр юу гэж ярьсан бэ гэхээр улсын төсөв дээр ийм хэмжээний ачаалал авч нэг амьсгаагаар шүүхийн байрны асуудал шийдэх нэгэнт боломжгүй нь тодорхой.

Харин төр, хувийн хэвшлийн түншлэлээр буюу концессоор Яармагт нэг шүүхийн цогцолборыг, зүүн талд нэг тойргийн шүүхийн цогцолборыг концессоор барьчихъя.

Өөрөөр хэлбэл 2 жилийн дотор шүүхийг ямар ч байсан байртай болгочихъё.

Тэгээд үүнийг концессоор шийдчихье гэсэн юм.

Тэгэхээр концессоор шийдэх шүүхийн байрыг барья гэдгийг нь хасчихаар бид одоо энэ хотын шүүхийн байруудыг мэдэхгүй байна. 10 жил лав болох байх. Улсын төсөвт суулгаад явна гэвэл 10 жил.

Одоо энэ байрууд чинь нурж уначих гээд байгаа шүү дээ. Сая намар манай Баянзүрхийн шүүх чинь бүр дулаангүй болсон шүү дээ. Энэ чинь хуучраад нурах хэмжээнд хүрчхээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь иргэдийн шударга ёсны үйлчилгээ авах эрхийг бид бас хангах ёстой.

Шударга шүүхээр шүүлгэх гэдэг чинь тийм боломжтой орчинтой шүүх байгууллагаар үйлчлүүлэх хүний эрхийн асуудал яригдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр орчин нөхцөл нь байхгүй байгаад байгаа юм.

Одоо Дархан аймгийн шүүх чинь Оросын Холбооны Улсын өмчийн байранд түрээсээр байгаа байхгүй юу. Монгол Улсын шүүхийн байр.

Тэгэхээр ийм 3, 4 аймгуудын асуудал актлагдаад нураах түвшинд орчихсон.

Одоо түрүүчийн 4 сард Хан-Уул дүүргийн иргэний шүүх актлах шийдвэр гараад ингээд нураагдах болчихоод байгаа байхгүй юу.

Одоо энэ шүүхийг яах вэ гээд Шүүхийн ерөнхий зөвлөл, дүүрэг нь надад хандаад байх юм.

Нэгэнт төсөв батлагдчихсан. Мөнгө байхгүй. Би энэ шүүхийн байр барих хаанаасаа.

Тэгээд би Төрийн өмчийн хороо руу л хандаад яваад байгаа. Энэ суларч байгаа янз бүрийн дэл сул байр байна уу. Иргэд үйлчлүүлэх иргэний шүүхгүй болчихоод байгаа байхгүй юу. Энэ Хан-Уулын шүүх.

Тэгэхээр ийм асуудлуудаа ерөөсөө юу гэж шийдье гэж ярьсан гэхээр концессоор шийдчихье. Тийм. Зам бариад л байдаг юм байна лээ. 2 шүүхийн байр барихад одоо юу шалиа аж дээ?

Тэгээд хурдан шийдчихье л гэж уг нь энэ тогтоолын төсөл дээрээ төр, хувийн хэвшлийн түншлэлээр байраа барьчихъя гэсэн байхгүй юу. Тэгээд тэрийг нь хасах гээд оруулж ирчихсэн байх юм.

Тэгэхээр энэ саналыг би дэмжихгүй л байгаад байгаа юм.

Д.Цогтбаатар: Г.Амартүвшин гишүүн хариулчих.

Г.Амартүвшин: Энэ асуудал дээр хуулийн төслийн ажлын хэсэг дээр ингэж ярьсан юм.

Ер нь мэдээжийн хэрэг бид шүүх байгууллагын байр савны асуудлыг маш хэцүү хурц байдалд байгаа гэдгийг ойлгож байгаа.

Тийм учраас бид энэ хуулийн төслийг аль болохоор энэ Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд яаралтай батлуулах ёстой гэсэн зарчмын дагуу энэ зарчмын зөрүүтэй саналуудыг бэлдсэн байгаа.

Зүгээр “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөлд иргэнд шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, зориулалтын шаардлага хангасан шүүхийн барилга байгууламж шинээр барихтай холбоотой төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх гэдгийг хасах нь Засгийн газрын хувьд төсвөөс ч санхүүжүүлж болно, шаардлагатай гэвэл төр, хувийн хэвшлийн түншлэлээр ч санхүүжүүлээд явж болно гэсэн. Өөрөөр хэлбэл тэр сонголт нь нээлттэй байгаа.

Үүнийг хассанаар Засгийн газар концесс юм уу, өөр төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар Шүүх байгууллагын барилга байгууламжийг барьж болохгүй гэсэн асуудал биш л дээ. Ийм зарчмаар, ийм логикоор бид ажлын хэсэг дээр үүнийг ярилцаад хасах нь зүйтэй юм байна.

Өөрөөр хэлбэл Засгийн газарт бүх тэр шаардлагатай сонголтыг нь хэвээр нь нээлттэй үлдээе гэсэн тийм зарчмаар бид энэ саналыг оруулж ирсэн юм. Б.Энхбаяр сайд аа.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр сайд аа, энэ чинь яг саяын ярьж байгаагаар нээлттэй. Таны саналтай нийцэж л байгаа юм байна шүү дээ.

Тэгэхээр дэмжээд явчих нь зөв байх аа. Яагаад гэвэл энд аль нэг юмыг хаагаагүй. Харин таны хүссэнээр ч гэсэн бас хийж болох өшөө нэмэлт хувилбарууд явж байгаа болохоор.

Тэрийгээ засаг дээрээ та нар шийдчих л дээ. Тэгэхгүй бид хааж өгөөд яах юм.

Тийм учраас бид хязгаарлахгүйгээр бид энд нээгээд өгчихье. Та хэд маань тэндээ очоод өөрсдөө шийдчих тэгэх үү.

Тэгэхээр тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх” гэснийг хасах гэдэг томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Энэ санал уналаа. Тэгээд та хэд маань өөрсдөө тэгээд тэндээ учраа олно биз.

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг хасах. Энэ томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх:

“3/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцсэн зориулалтын шаардлага хангасан шүүхийн байраар хангах хүртэлх хугацаанд нийслэл дэх зарим шүүхийг байраар хангаж, шүүн таслах ажиллагааг

тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;”

Санал гаргасан “Ажлын хэсэг”.

58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

“4/Нийслэлд гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны тойргийн шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;”

Санал гаргасан “Ажлын хэсэг”.
Санал хураалт. /алх цохив/

58.3 хувиар санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

“5/Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн давж заалдах шатны шүүхийг тойргоор байгуулах асуудлыг судалж, холбогдох хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;”

Санал гаргасан “Ажлын хэсэг”.
Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх:

“6/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг эрэн сурвалжлах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэгжийн орон тоо, төсвийг нэмэгдүүлэх, холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.”

Санал гаргасан “Ажлын хэсэг”.
Санал хураалт. /алх цохив/

Н.Учрал гишүүн горимын санал гаргах уу?

Н.Учрал: Энэ дэмжиж санал өгсөн. Орсонгүй ээ. Дахиж санал хураалгаж өгөөч.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. 66%

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүн саналын томьёололыг уншаад танилцуулчихсан байгаа. Түрүүний томьёоллоор санал хураалт явуулъя.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал

хураалтаа явуулж эхэлье. 2 саналтай байгаа.

Энэ эхний саналаар санал хураалт явуулахгүй яагаад гэвэл нөгөө түрүүчийн санал хураалтаар санал уначихсан учраас.

Тийм учраас одоо шууд хоёр дахь саналаар нь санал хураалтаа явуулъя.

8.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Шүүх байгуулах тухай /Шинэчилсэн найруулга/ баталсантай холбогдуулан прокурорын байгууллагын орон тоо, төсөвт өөрчлөлт орох эсэхийг судлан үзэж, шаардлагатай бол саналаа боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэхийг Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайханд.”

Санал гаргасан “Ажлын хэсэг”.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн саналгүй байгаа.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин уншчихъя.

Дараагийн асуудалдаа оръё.

Дөрөв. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хууль зүйн байнгын хорооны хурлаа үргэлжлүүлж явуулъя.

Одоо дөрөвдүгээр асуудал.

Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Н.Даваадогтох, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн М.Ганбагана.

Ийм албан тушаалтнууд ажлын хэсэгт орж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцье.

“Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналгүй.

Тогтоолын төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналгүй.

Тогтоолын төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө бол асар чухал бодлогын болон эрх зүйн үр дагавартай баримт бичиг байгаа.

Энэ төлөвлөгөөнд заасан ажлууд маань хэрэгжиж, холбогдох хууль эрх

зүй, бодлогын орчнуудыг сайн гаргаж чадсан тохиолдолд Монгол дахь авлигалын томоохон дэвшил гарна. Авлигалын эсрэг бодлогууд үр дүнд хүрнэ. Холбогдох төрийн бус байгууллага, төрийн байгууллагууд болон ард нийтийн ч гэсэн хүлээлт энэ дээр асар өндөр байгаа.

Тэгээд хоёр асуулт байгаа. Манай энэ төлөвлөгөө дээр хамгийн чухал нэг заалт бол сонгуулийн болон сонгуулийн бус бүх үед тодорхой Улсын Их Хурлын гишүүн, аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гишүүд сонгогчдын санал авах зорилгоор ямар нэгэн биет болон биет бус байдлаар сонгогчдыг хөхиүлэн дэмжих, урамшуулах зардал, юуг нь даах зэрэг энэ асуудлыг бүрмөсөн хориглох эрх зүйн шинэчлэлийг хийхээр үүрэг болгож байгаа.

Ер нь сонгуулийн болон далд сурталчилгаа, далд авлигын хэлбэр шүү дээ. Жишээлбэл, маш олон улс төрчид өөрсдийн нэртэй гэдэг юм уу, хэн нэгний нэрээр сан ажиллуулаад, энэ сангаар дамжуулан сонгогчдод бэлэн болон бэлэн бус мөнгөний дэмжлэг үзүүлэх, ийш тийш аялуулах явдал маш түгээмэл байдаг.

Энэ бол авлигалын далд хэлбэр.

Тэгэхээр үүний эсрэг эрх зүйн тогтолцоо, бодлогуудыг оруулж ирэх чухал байгаа.

Энэ дээр манай Авлигатай тэмцэх газар ямар байр суурьтай бодлого, эсвэл Засгийн газраас хуулийн төсөл өргөн барих вэ гэдгийг нэгд асууя.

Хоёр дахь анхаарал татаж байгаа зүйл бол ер нь энэ авлигын гэмт хэрэгт

буюу шударга бусаар гэмт хэргийн замаар хөрөнгө орлого олсон албан тушаалтнууд оффшор болон бусад газар үл хөдлөх хөрөнгөө байршуулж хилийн чанадад банк болон бусад байдлаар үл хөдлөх хөрөнгө авч байгаа нь их түгээмэл байна.

Хэвлэл мэдээллээр бас нэр бүхий нэлээд олон улс төрчдийн асуудал, Америк дахь тодорхой үл хөдлөх хөрөнгүүд нь Америкийн хуулийн эрх зүйн дагуу бас ил болж, тэр нь олон нийтэд мэдээллийн чанартай буюу яг хууль, шүүхийн байгууллага маань энд хэр орж байна гэдэг нь тодорхойгүй байгаа.

Тийм учраас Авлигатай тэмцэх газраас энэ шилжүүлэн авах ажиллагаа буюу Засгийн газрын “Таван Ш” ажиллагааны үр дүнд ер нь энэ оффшорт нуусан, гэмт хэргийн замаар хөрөнгөө нуун далдалсан энэ хэрэг маань хэр ямаршуу явж байна аа? Яг тодорхой мөнгөн дүн, тодорхой мөнгөн биет хөрөнгөөр илэрсэн шилжүүлэн авсан үл хөдлөх байна уу гэдгийг бас асууя.

Ер нь энэ чиглэлд цаашдаа бид олон улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээгээ илүү өргөжүүлэх шаардлага байгаа. Ялангуяа Америкийн Нэгдсэн Улстай гэрээний хамтран ажиллах шаардлага байгаа.

Тэгэхээр энэ хоёр асуултад хариулт авъя.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хариулъя. 5 дугаар микрофон.

Д.Дуламсүрэн: Сайн байна уу?

Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Авлигатай тэмцэх газрын
Д.Дуламсүрэн байна.

Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг Улсын Их Хурлаас батлахдаа яг саяын сонгуулийн бус үеэр санал худалдан авахтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байгаа.

Энэ хүрээнд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд бид хоёр зүйл дээр төвлөрч ажиллахаар төсөлд тусгасан.

Нэгдүгээрт, мэдээж Улсын Их Хурлын гишүүн, бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нар бүрэн эрхийнхээ хугацаанд иргэдэд мөнгө ч юм уу, эд зүйл, эдийн бус хөрөнгө тараах, тэдгээрийн өмчлөх эрхийг шилжүүлэх, төлбөргүй, эсвэл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх, эсвэл эдгээрийг бас амлах, санал болгох зэрэг энэ бүх төрлийн санал худалдан авах үйлдэл гаргахыг хориглох ийм эрх зүйн зохицуулалтыг бий болгохын тулд Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу гурван төрлийн судалгааг хийх гэж байгаа.

Нэгдүгээрт, мэдээж хууль тогтоомжийн төслийн тандан судалгаа. Энэ хуулийн төсөл хэрэв батлагдах бол ямар хэмжээний эдийн засгийн, тийм ээ зардал гарах юм бэ гэдэг энэ эдийн засгийн зардлын тооцоо. Мөн энэ хуулийн төсөл батлагдсанаар ямар үр нөлөө нийгэм, эдийн засаг, улс төрд үзүүлж болох вэ гэсэн ийм судалгаануудыг хийхээр нэгдүгээрт тусгасан байгаа.

Дараагаар нь яг энэ чиглэлээр хуулийн төслийг Хууль зүй, дотоод

хэргийн яам, Авлигатай тэмцэх газар, мөн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч төсөл боловсруулж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно. Үүнийг ойрын хугацаанд ерөнхийдөө зохион байгуулъя гэсэн ийм төлөвлөлттэйгөөр ажиллахаар байгаа.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон.

Н.Даваатогтох: Гишүүний асуултад хариулъя. Авлигатай тэмцэх газрын хэлтсийн дарга Н.Даваатогтох.

Авлигатай тэмцэх газраас сүүлийн гурван жилийн хугацаанд авлигын гэмт хэргийн улмаас хулгайлагдаж гадаад улсад байршсан 12.2 сая долларын хөрөнгийг буцаан авчирсан байгаа.

Хөрөнгө буцаан авах ажиллагаа өөрөө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаанууд дундаас хамгийн их ур чадвар шаардсан ажиллагаа байдаг. Энэ олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн ийм ажиллагаа байгаа.

Гадаад улсаас хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах ажиллагаанд 2-оос 3 улсын мөрдөн шалгах байгууллагууд хамтарч ажиллах шаардлага үүсдэг.

Дээр нь тухайн улсуудын хууль тогтоомжуудыг бас ойлгож энэ ажиллагаанд хэрэглэх гээд тухайн ажиллагаанд оролцож байгаа ажилтнуудаас хуульч, эрх зүйч чадвараас гадна гадаад хэлний мэдлэг гэдэг юм уу, хөрөнгө санхүүтэй холбоотой санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой нарийн мэдлэгүүд шаарддаг ийм томоохон ажиллагаа байдаг.

Авлигатай тэмцэх газраас бид яг одоогийн байгаа хууль тогтоомждоо зохицуулаад өөрийн боломжоор ажиллаж байгаа.

Одоо Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42.1-д тодорхой гадаад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар бол эрх зүйн харилцан туслалцааны гэрээ нэгд байх ёстой.

Хоёр дахь асуудал нь, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг ашиглаж явуулах ийм боломжтой байгаа. Хууль тогтоомжийн хүрээнд, Монгол Улс 2005 онд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг соёрхон баталсан.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг удирдлага болгоод өнөөдөр Авлигатай тэмцэх газраас хөрөнгө буцаан авах ажиллагаануудыг гадаадад улсын тодорхой ижил чиг үүргийн байгууллагуудтайгаа хамтраад үр дүнтэй ажиллаж байна. Та тодорхой тоо хэлээч гэдэг ийм асуулт тавьсан.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсаас 4.9 сая долларын хөрөнгийг эх орондоо авчирсан. Британийн Виржиний арлуудаас 1.6 сая ам.доллартой тэнцэх. Мөн Америкийн Нэгдсэн Улсаас 5.7 сая ам.доллартой тэнцэх хөрөнгийг Монгол Улсдаа буцаан авчирсан үр дүнтэй ажиллаж байна.

Яг одоогоор Авлигатай тэмцэх газраас Латви Улсын арилжааны банканд байгаа 540 мянган ам.долларыг буцаан авахаар тухайн улсын хууль сахиулах байгууллагынхантай хамтраад ажиллаад явж байна. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Хариулт авч дуусав уу?

Ингээд саяын энэ тогтоолын төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналгүй.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Ингээд энэ хэлэлцүүлэгтэй холбогдуулаад бас горимын санал гаргах хүсэлтэй байна.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууссантай холбогдуулан тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Хамтатгаад нэг мөр явуулчихъя гээд. Энэ санал хураалтыг хүчингүй болгоё. Түр хүлээж байя.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

54.5 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг

танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё.

**Тав. “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн
албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Г.Азжаргал Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Н.Даваатогтох Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар.

Ийм хүмүүс ажлын хэсгийг төлөөлж байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

54.5 хувиар санал дэмжигдлээ.

“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулъя.

Дараагийн асуудалдаа оръё.

Зургаа. Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2024.05.01-ний өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг,
Санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Байнгын хорооныхоо хурлыг үргэлжлүүлбэ. Зургадугаар асуудал.

Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт

өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Пүрэвжавын Сайнзориг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга Дугаржавын Амгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Бат-Эрдэнийн Төрбат, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Мөнхөөгийн Батбаяр, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Ерөнхий менежер Баатарын Гүнболд, Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах хорооны Ажлын албаны төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч Цогтгэрэлийн Батгэрэл, Нийслэлийн Засаг даргын Тамгын гзарын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Дэмбэрэлийн Батцэнгэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн Сумьяасүрэнгийн Энхжаргал, Нийслэлийн Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн Мөнхбаярын Уранбилэг гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Байнгын хорооны хуралдаанд оролцож байна.

Энэ асуудал хэлэлцэхэд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Энд нэг зарчмын санал байгаа. Нэг төслийн 1 дүгээр зүйлийн “тухайн хотод” гэснийг “тухайн шүүхэд” гэж өөрчлөх.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

54.5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын

байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан танилцуулчих. Тийм.

Долдугаар асуудал. Сүүлийн асуудал байгаа.

Долоо.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

/Улсын Их Хурлын С.Одонтуяа нарын гишүүд 2024.04.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

С.Одонтуяа гишүүний өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа.

С.Одонтуяа нарын гишүүд 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Салдангийн С.Одонтуяад танилцуулна.

С.Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны гишүүд ээ,

Улсын Их Хурлаас Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод 2002 онд, нэмэлт протоколд 2015 онд нэгдэн орж соёрхон батлаад 9 жил өнгөрч байна.

Монгол Улс соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсон үүргийнхээ дагуу дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх үүрэгтэй.

Миний бие энэхүү хуулийн төслийг өргөн барихаар боловсруулахдаа Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний нэмэлт протокол, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж 2016 он, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал, түүний тайлан зөвлөмжүүд 2017, НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Хүний эрхийн зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж, Монгол Улсад ирүүлсэн зөвлөмжүүд, түүнчлэн НҮБ-ын болон олон улсын байгууллагуудын тайлан зөвлөмжид нийцүүлэн гаргасан Улсын Их Хурлын 2022 оны 49, 2023 оны 35, 144 дүгээр тогтоолууд, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоол болон Хүний эрхийн Үндэсний Комиссоос жил бүр гаргадаг Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн шаардлагыг үндэслэл болгон хуулийн төслөө боловсруулсан болно.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчлэн батлахдаа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний бүрэн эрх, чиг үүрэг, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгасан.

Тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт, шинжилгээ хийх гэсэн заалтыг бүх газар гэдэгт зэвсэгт хүчин, таслал хилийн болон дотоодын цэргийн анги гэсэн нэмэлтийг оруулж байна.

Сүүлийн жилүүдэд Зэвсэгт хүчний цэргийн анги нэгтгэлд дүрмийн бусаар харьцах, нэгэндээ хүнлэг бусаар хандах, ялгаварлах, бие махбодод гэмтэл учруулах, бүр амь нас хохирох явдал ил тод хэлбэрээр гарсаар байгаа нөхцөл байдлыг таслан зогсох, дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, тогтмол хяналт шинжилгээ хийх чиг үүргийг Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхэд шинээр тусган нэмэлт оруулж байна.

Иргэд өөрийн хүслээр явж чадахгүй эрхээ хязгаарлуулсан газар, мөн цагдаагийн байгууллага болон прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зэрэг аливаа хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатад эрүүдэн шүүхээс ангид байх эрхтэй.

Иймээс Эрүүгийн хуулийн 21.12-т заасан гэмт хэргийн өнөөгийн зохицуулалтаар төрийн албан хаагч тайлбар мэдүүлэг авахдаа эрүү шүүлтийг хориглосон байхаар байгаа нь учир дутагдалтай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь олон үйлдлүүд хамрагдалгүй орхисон хийдэлтэй байгааг зохицуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатад эрүү шүүлтээс ангид байхаар нэр томьёоны хувьд оновчтой болгон конвенцод нийцүүлсэн нэмэлт, өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулсан болно.

Хуулийн төслөө боловсруулахдаа НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг дэд хорооны гишүүдээс санал авахаар хүргүүлсэн бөгөөд хуулийн төслийг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн дэд хорооны зөвлөлөөр хэлэлцээд 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн албан захидлын ирүүлсэн болно.

Энэхүү албан захидалд дурдахдаа Монгол Улс дахь урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хуулийн төсөлд санал авч байгаад талархал илэрхийлээд, нэмэлт протоколын 32 дугаар зүйлийн орон тоо, нэгж, төсвийн тусдаа байдал, томилох, захиран зарцуу болох эрхийг хангасан байх.

Мөн Конвенцын 142 дугаар зүйл төсвийг цагариган тойрогт оруулах заалтыг хангаж байгааг талархан цохон тэмдэглэсэн байна.

Уг хуулийн төсөл баримтлалыг доорх агуулгаар хангахаар тусгалаа.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын 18 дугаар зүйлд оролцогч улсууд үндэсний

урьдчилан сэргийлэх байгууллага чиг үүргийнхээ хувьд хүний нөөц, төсөв, хөрөнгө, үйл ажиллагааны хараат бус байх баталгааг хангана.

Оролцогч улс мөн үндэсний байгууллагын статустай холбоотой зарчмыг нэмэлт протоколд заасны дагуу зохих ёсоор харгалзаж үзнэ гэж заасныг баримталсан болно.

Эрхэм байнгын хорооны гишүүд ээ,

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон Эрүүгийн хуульд оруулж буй хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үзэл баримтлалын хүрээнд дэмжин шийдвэрлэж өгнө үү.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгийг танилцуулъя.

Хуралдаанд дараах бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Д.Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Б.Энхболд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Г.Нарантуяа Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Я.Цэлмэн Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Ш.Үнэнтөгс Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Т.Амарзаяа Улсын Ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор, Б.Нямгомбо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа, Ч.Өнөржаргал, хуульч, өмгөөлөгч, П.Цэцэгмаа Улсын Их Хурлын гишүүн

С.Одонтуяагийн зөвлөх гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Б.Энхбаяр гишүүн байна. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: С.Одонтуяа гишүүнээс бүрэн эрхийнхээ хүрээнд санаачилсан Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд Засгийн газар саналаа өгсөн байгаа.

Засгийн газар дэмжихгүй санал өгсөн.

Дэмжихгүй гэж байгаагийн гол үндэслэл нь эрүүдэн шүүхтэй тэмцье гэсэн энэ улс төрийн хүсэл зориг, эрүүдэн шүүхтэй тэмцэх ялын бодлогыг чангалъя гэдэгтэй санал нэг байгаа.

Ямар арга замаар вэ гэдэг дээр байр суурийн зөрүүтэй байгаа.

Энэ нь нэгд ямар зөрүү вэ гэхээр бид 2019 онд Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулж эрүүдэн шүүхтэй эвлэрэхгүй гэдгээ Монгол Улсын төр, засаг бодлогоо тодорхойлж, Эрүүдэн шүүхийн эсрэг Хүний эрхийн комисст бие даасан комиссарыг байгуулсан.

Энэ комиссарыг 2021 онд бие даасан байдлаар байгуулж ажиллаж байгаа.

Хамгийн гол нь энэ комиссоор нь С.Одонтуяа гишүүний хуулийн төслөөр төсөв, санхүү, хүний нөөцийн бие даасан байдалтай буюу Хүний эрхийн комиссоос тусдаа салж гарах гээд байгаа юм.

Хүнээ өөрөө томилно, төсвөө өөрөө зарцуулна гэдэг бол бие даасан байгууллагын дарга болно гэсэн үг.

Тэгээд заавал энэ мөнгө төгрөг зарцуулж хүн томилж байж энэ эрүүдэн шүүхтэй тэмцэнэ гээд байгаа энэ байр суурийг нь ойлгохгүй байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комисс гэж нэг л байгууллага байгаа.

Энэ дотроо эрүүдэн шүүхийн эсрэг бие даасан комиссар нь бусад комиссаруудаасаа харьцангуй бие даасан байдлаар санал, дүгнэлтээ гаргадаг, хяналт шалгалтаа хийдэг ийм хууль эрх зүйн орчинтой.

Тэгэхээр юу дутаад байгаа юм бэ гэж хэлэх гээд байгаа юм.

Ажлаа хийх хэрэгтэй шүү дээ. Ямар ч байгууллагад, хэнийг ч хүлээлгүйгээр, ямар ч саадгүйгээр нэвтрэх, хянан шалгах, дүгнэлт гаргах ийм онцгой бүрэн эрхтэй комиссар.

Заавал мөнгө төгрөг зарцуулдаг, хүн томилдог, дарга болж байж ажлаа хийнэ гээд байгааг нь ойлгохгүй байгаа.

Томилогдсоноосоо хойш хоёр, гурван жил ийм юм ярьж явж байна.

Тэгээд гишүүдийг лоббидож салан тусгаарлах, төлөвшиж байгаа байгууллагыг хуваах энэ ажлаа одоо болих хэрэгтэй.

Тийм учраас Засгийн газар энэ хуулийн төслийг дэмжихгүй байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комисс өөрөө дэмжихгүй байгаа.

Санал, дүгнэлт нь ирсэн. Комисс нь өөрөө ч дэмжихгүй байгаа, Засгийн газар ч дэмжихгүй байгаа.

Тийм учраас одоо энэ гишүүдийг лоббидож энэ салан тусгаарлах үйл ажиллагаа явуулж, өөрөө дарга цэрэг болох гэдэг энэ нэг амбицаа одоо боль.

Д.Цогтбаатар: Уг нь хариу байхгүй. Энэ чинь асуулт биш юм чинь. Гэхдээ С.Одонтуяа гишүүн үг хэлье.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ ийм учиртай юм.

Одоо надад тэр эрүүдэн шүүхийн урьдчилан сэргийлэх газар хэн байна, ямар дарга байна. Тэр бол ерөөсөө сонин биш.

Бид энэ олон улсын зөвлөмжүүдээ л дагаж ажиллаж гэж байгаа юм.

Б.Энхбаяр сайд сайд болохдоо хамгийн анхны чуулган дээр тэгж хэлж байсан. Энэ олон улсын зөвлөмж, нийтлэг энэ конвенцод хэрэглэдэг хүний эрхийн энэ үг хэллэг, бүх зүйлд бид Монголд нутагшуулах талаар ажиллана, ажиллагаа зохион байгуулна гэж.

Тэгэхээр үүнийг энэ байгууллагын хүмүүс лоббидоод байгаа юм биш ээ. Үүнийг олон улсын хүний эрхийн энэ

эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх комиссарууд танайд ийм байгаа нь сэтгэл зовниж байгаа асуудлын нэг яах аргагүй мөн шүү гэдгийг хэлчихсэн байгаа юм.

Хараат байна. Төсөв санхүү дээр л гол нь хараат бус бус байх ёстой байдаг.

Яагаад гэхээр та нар одоо энэ түүхийн явцыг аваад үзээрэй. Эрүүдэн шүүж байгаа хүмүүс дандаа ардаа том артай, том даргын захиалгаар, улс төрийн захиалгаар эрүүдэн шүүдэг. Түүнээс зүв зүгээр жирийн нэг хүн очоод тэнд эрүүдэн шүүлт нэг их явуулаад байдаг юм байдаггүй.

Тийм учраас олон улсын зөвлөмжид алдаа гаргахгүйн тулд энэ бүх зүйл чинь хараат бус байх ёстой юм шүү гэдэг энэ зөвлөмжийг өгч байгаа юм.

Тэгэхээр манайд одоо хараат бус байж чадахгүй байгаа юм.

Хууль зүйн сайд Хууль зүйн байнгын хороон дарга байхдаа тогтоол гаргасан байдаг. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хараат бус болгоно гээд.

Тэгээд тэр данс нь нээгдсэн нэртэй, хоосон л байж байдаг.

Одоо яах вэ Хүний эрхийн Үндэсний Комиссынхоо даргаас л нэг хэд гурван мөнгөө гуйж байж, шийдүүлж байж, ингэж л байж байгаа. Энэ чинь олон улсын яг эрүүдэн шүүхийн энэ конвенц нь хамгийн сөрөг үр дагавар авчирдаг заалт байхгүй юу.

Сая Нэгдсэн Үндэстний Байгууллагын комиссарууд нь ирээд уулзлаа.

Өнөөдөр Монгол Улсад хүний эрх зөрчигдөж байгааг энэ ингээд бүтэн номоор гаргасан байна. Үүнийг нэг бүрчлэн уншлаа. Би энэ хүний эрхийн зөрчлийг л арилгая гээд байгаа болохоос надад тэр гишүүн нь хэн байна. Өнөөдөр энэ дээр ямар нэгэн лобби явуулах гэж байгаа ямар ч ашиг сонирхол байхгүй.

Хоёрдугаарт, батлан хамгаалахын салбарт ямар их хүний амь үрэгдэж байгааг та нар мэдэж байгаа шүү дээ.

Тэгээд хүний амь үрэгдэхээр нь л монголчууд нэг сенсаалдаг. Тэгээд бусад үед мартчихдаг. Энэ хуулийн чинь гол заалт нь энэ зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэргийн ангиудад орж энэ урьдчилан сэргийлэх зүйл, заалтаа хийгээч ээ л гэсэн санаа шүү дээ.

Урьдчилан сэргийлэх юм хийгээд байх юм бол тэнд хүний амь эрсдэхгүй. Тэнд төрийн албан хаагчийг сургаад байх юм бол хүний амь эрсдэхгүй. Би энэ урьдчилан сэргийлэх ажиллагааг чинь хийх нь чухал юм гэдгийг л энэ салбарт оруулж ирж байгаа.

Гурав дахь чухал заалт бол зөвхөн мэдүүлэг авахдаа эрүүдэн шүүж болохгүй ээ гэдэг заалт чинь хэтэрхий болохгүй байна. Явцуу байна.

Өнөөдөр маш олон процесс дээр эрүүдэн шүүхийн л үзүүлэлтүүд гарч ирж байна. Нотлох баримт цуглуулах, баримтжуулах бүхий л шатад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүхий л үйл ажиллагаанд эрүүдэн шүүхийн элементүүд оршсоор байна шүү дээ.

Тэгээд энэ хуулийг ингээд санаачлаад ороод ирэхээр салан тусгаарлах гэж байна гэж ингэж ерөөсөө болохгүй.

Би зүгээр хараат бус байлгая л гэж байгаа. Түүнээс биш тэр ямар байгууллага хэн дотроо байх нь надад ерөөсөө хамаагүй. Ерөөсөө би сайдаас тийм л юм асууж байгаа. Та өөрөө сая хурлын өмнө надад хэлсэн шүү дээ. Хараат бус байлгая л гэж.

Тэгэхээр би юу гэсэн хүсэл лт байна гэхээр хэлэлцэх эсэхийг нь дэмжээд өгөөч ээ. Тэгээд яг тэр байгууллагын асуудал дээр ажлын хэсгийн гишүүд ажиллаад тэр саналуудаа гаргая л даа. Хэлэлцээд яриад явъя.

Тэгэхгүй бол миний тэр батлан хамгаалахад гол урьдчилан сэргийлэх ажиллагааны заалт чинь энэ хуультайгаа уначих гээд байна шүү дээ.

Тэгэхээр л би энэ саналыг л дэвшүүлсэн юм. Тийм.

Д.Цогтбаатар: Энэ асуудалтай холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа. Би нэг ганц зүйл хэлье.

Би хүний эрхийн комиссыг байнга өмөөрч дэмжиж байдаг.

Энэ удаа би та нарыг шүүмжилмээр байна. Та нарт өгч байгаа энэ Их Хурлаас өгөх болсон дэмжлэгийн хэмжээнд та нар ажиллахгүй байна.

Дотроо хагаралтай. Юун хүний эрхийн. Та нар дотроо албан тушаалын суудалтайгаа толхилцож байхад юун хүний эрхийн асуудал ярих манатай болчихсон байж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээрээ та нар анхаарах хэрэгтэй. Ний нуугүй л ярья.

Та нарын дотоод хэрүүл жинхэнээрээ 100 дугаар асуудал шүү. Иргэдийн эрх зөрчигдөөд байгаа нэгдүгээр асуудал байгаа байхгүй юу. Түүн дээрээ та нар илүү анхаараач.

Тэгэхээр энэ дээр нэг удаа би бас хатуу үг хэлмээр байна шүү. Харин.

Б.Энхбаяр гишүүний хэлж байгаа зөв. Яагаад гэвэл ингэж харагдаад байгаа юм. Харагдаад байгаа юм.

С.Одонтуяа гишүүний сая оруулж ирж байгаа юу нь тэр хараат бус байлгах ёстой. Би тэр хараат бус байлгах нь дэмжиж байгаа.

Тэгэхдээ хараат бус байлгана гээд заавал тусдаа гарах гээд албан тушаалын асуудал аваад ороод ирэхээр чинь гишүүд ийм л хандлага гаргана шүү дээ. Зарчмын асуудал чинь ерөөсөө л ийм байгаа юм.

Түүнээс энд С.Одонтуяа гишүүн бол хүний эрхийн асуудлыг тууштай ярьж байгаа.

Хүний эрхийн асуудал харин ярихгүй болчихсон, ярьдаггүй гишүүн манай Байнгын хороонд одоо байхгүй болсон шүү. Бүгдээрээ хүний эрхийн төлөө л байгаа.

Тэгээд энэ дээр тал талдаа бодох асуудал байна. Энэ оруулж ирж байгаа асуудал дээр оруулж ирж байгаа гишүүний сая тавьж байгаа энэ хараат бус байх ёстой. Эрүүдэн шүүхтэй холбогдсон асуудал.

Энэ нь ямар ч тохиолдолд хараат бус байх ёстой шүү. Наад хүн чинь хараат байгаад байгаа учраас энэ асуудлыг гишүүдтэй ярьж байгаад бас оруулж ирж байна шүү дээ.

Үүнийгээ тэгэхээр бодох ёстой. Эндээс зөндөө л дэмжлээ. Тэгээд ийм асуудал бариад л өөрсдөө орж ирээд л явж байна гэдэг бол зөв биш. Ийм байна.

Тэгээд одоо энэ дээр санал хураалтаа явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын гишүүд 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

18.2 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүддээ ирж оролцсонд талархаж байна.

Хуралдаан 4 цаг 36 минут үргэлжилж, 16 цаг 13 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД